

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7-45

<i>1.Байнгын хорооны тогтоолын төсөл/Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/</i>	7-8
<i>2.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/</i>	8-26
<i>3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	26-38
<i>4.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	38-45

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
10 дугаар сарын 25-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 07 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Амартүвшин, Э.Бат-Амгалан, С.Бямбацогт, Д.Ганбат,
Б.Дэлгэрсайхан, Ц.Сандаг-Очир;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөхийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан санал хэлэв.

Д.Цогтбаатар: Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан

үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын дарга, тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын аудитын удирдлагын менежер Л.Мөнхцацрал, Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын менежер Х.Баярмаа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Д.Зүмбэрэллхам, мөн зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Р.Батрагчаа, Шүүхийн сахилгын хорооны гишүүн Д.Эрдэнэчулуун, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, мөн газрын ахлах нягтлан бодогч Б.Бадамсэрээжид, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, мөн газрын ахлах нягтлан бодогч Б.Эрдэнэбат, Авлигатай тэмцэх газрын дэд дарга Г.Азжаргал, мөн газрын Тамгын газрын дарга З.Баасанням, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Ажлын албаны дарга Л.Очирсүрэн, мөн комиссын нарийн бичгийн дарга Г.Төгөлдөр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, мөн хэлтсийн мэргэжилтэн С.Гэлэгжунай, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн хэлтсийн ахлах шинжээч Д.Отгонжаргал, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Энхтуяа, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Гантуяа, мөн газрын Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн хэлтсийн ахлах шинжээч Г.Базаргүр, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга Л.Нямгэрэл, мөн албаны Санхүүгийн хэлтсийн дарга Т.Алтанцэцэг, Цагдаагийн ерөнхий газрын дарга Т.Сүхболд, мөн газрын Санхүүгийн хэлтсийн дарга Н.Алтансүх, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Х.Лхагвасүрэн, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ц.Чойжилсүрэн, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, мөн газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Б.Өэлүн-Үжин, Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга Ж.Буянбат, мөн газрын Санхүү, хангамжийн хэлтсийн дарга Х.Саранчимэг, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр, мөн газрын Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Солонго, Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатар, мөн газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Х.Цогтбаатар, Оюуны өмчийн газрын дарга Г.Элбэгсайхан, мөн газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга С.Содгэрэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга Б.Нандинболор, мөн газрын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын дарга А.Намсаманд, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Х.Бат-Ирээдүй, мөн эмнэлгийн Санхүү, хангамжийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Оюунтөгс, Дотоод хэргийн их сургуулийн захирал П.Батбаатар, мөн сургуулийн Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ч.Лхагважав, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, мөн хүрээлэнгийн ахлах нягтлан бодогч Д.Урантуяа, Хууль зүйн туслалцааны төвийн захирал В.Оюумаа, мөн төвийн ахлах нягтлан бодогч Л.Болор-Эрдэнэ, Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн дарга П.Энхбаяр, мөн төвийн Санхүү, аж ахуйн тасгийн дарга П.Доржготов нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөхийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Золжаргал, референт П.Хулан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт,

шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөхийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батцэнгэл, референт Ц.Отгонбаатар, С.Төрмөнх нар байлцав.

Төсвийн төслийн танилцуулгыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Б.Энх-Амгалан, Л.Мөнхбаатар, Ш.Раднаасэд нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Авлигатай тэмцэх газрын дэд дарга Г.Азжаргал, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын зардлаас 310 сая төгрөг бууруулж, Хил хамгаалах ерөнхий газрын хил хамгаалах салбаруудын их засварын зардлыг 310 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 10
Бүгд: 12
16.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Сангийн сайдын багцаас 9.1.3.1-д заасан 36 тэрбум, 9.2.3.1-д заасан 7 тэрбум, 93.2.3.2-д заасан 9 тэрбум төгрөгийг тус тус бууруулж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн зардлыг 58.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 7
Бүгд: 12
41.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 6
Бүгд: 12
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцад салбарын барилга байгууламжийн их засварт төлөвлөсөн 6,4 тэрбум төгрөгийн зардал дотор Гадаадын иргэн, харьяатын газрын Баруун бүс дэх газрын үйлчилгээний барилгын нэмэлт ажлын төсөв 423,8 сая төгрөг гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.Галбадар, Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, мөн газрын мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга Б.Нандинболор, Цагдаагийн ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, мөн газрын Экологийн цагдаагийн албаны дэд дарга Б.Батсуурь, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга Д.Энхтөр, Эрүүгийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, боловсронгуй болгох чиг үүрэг бүхий Байнгын ажлын хэсгийн гишүүн Б.Гантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөхийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр танилцуулав.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ш.Адъяаа, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах нар хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын дээд шүүхийн шүүгч Н.Баярмаа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Б.Ундрах, Н.Баасанжав, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Жамъянхүү, мөн хэлтсийн шинжээч М.Цолмон нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөхийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр танилцуулав.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын дээд шүүхийн шүүгч Н.Баярмаа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Баасанжав нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд үг хэлэв.

Д.Цогтбаатар: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 20 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 01 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 20 цаг 08 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
17 цаг 07 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдээ энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул ХЗБХ-ны 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн ирсэн байна, Лхагвын Мөнхбаатар гишүүн ирсэн байна, Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн ирсэн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн байна, Шатарбалын Раднаасэд гишүүн ирсэн байна, Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн ирсэн байна, Цэдэвийн Сэргэлэн гишүүн ирсэн байна, Ням-Осорын Учрал гишүүн ирсэн байна, Баттөмөрийн Энхбаяр гишүүн ирсэн байгаа, Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн ирснээр ингээд ирц бүрдээд, хуралдааны ирц бүрдсэн байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1-д Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл, 2-т Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд, 3-д Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн

хуулийн төсөл, 4-д Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл гэсэн ийм 4 асуудал байна. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байхгүй тул хэлэлцэх асуудлыг баталлаа. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Нэг дэх асуудал Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү? Байхгүй байна. Энх-Амгалан гишүүнээр тасаллаа.

Б.Энх-Амгалан: Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 10 сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсэг Сандаг-Очир гишүүнээр ахлуулаад гарч байгаа юм байна. Энэ ажлын хэсэгт нэмж орж болох уу эсвэл бүүр батлагдаад болчихсон уу? Нэмж орж болно гэвэл би орчхож болох уу? Болно гэвэл та тогтоол дээр нэмээд оруулчихаач.

Д.Цогтбаатар: Болно. Одоо яг л хэлэлцэж байгаа юм чинь.

Б.Энх-Амгалан: За.

Д.Цогтбаатар: Тэгвэл одоо энд юу та нарт тараасан төсөл дээрээ тэгвэл ингээд ойлгогдохгүй. Раднаасэд гишүүний оронд Энх-Амгалан гишүүнийг, тэгье, тэгье, ойлголоо. Раднаасэд гишүүн өөрөө санал гаргаж байгаа юм бол, тэгвэл ингээд Раднаасэд гишүүний оронд

Энх-Амгалан гишүүнийг оруулаад төслийг тэгж баталъя. Тэгж шинэчилсэн байдлаар. Ингээд энэ төсөл дээр өөр асуух асуулттай гишүүд байхгүй бол, үг хэлэх гишүүн байна уу? Тэгвэл төслийг юу баталъя гэсэн томъёоллоор санал хураая. Томъёолол нь хаана байна вэ? Тогтоолын төслийг танилцуулъя. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол. Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн ХЗБХ-ноос тогтоох нь.

Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир Улсын Их Хурлын, гишүүн гишүүд Адьшаа Улсын Их Хурлын гишүүн, Амартүвшин Улсын Их Хурлын, гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын гишүүн, Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын гишүүн, Ш.Раднаасэд Улсын Их Хурлын гишүүн Раднаасэдийн оронд яг үнэн, Б.Энх-Амгалан Улсын Их Хурлын гишүүн, Ж.Сүхбаатар Улсын Их Хурлын гишүүн. Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар Г.Золжаргал хууль зүй, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн ХЗБХ хариуцсан ахлах зөвлөх. Тэгээд үүгээр ийм бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг байгуулъя гэсэн томъёололтойгоор санал хураая. Хуралдаанд оролцсон гишүүдийн 75 хувийн саналаар Ажлын хэсэг байгуулах санал дэмжигдлээ.

17.14 цаг

Хоёр. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны

төсвийн тухай хуулийн төслүүд
/Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

2 дахь асуудалдаа оръё. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулъя. Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Сангийн сайд ирсэн байгаа юу? Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Сангийн сайд өөр Байнгын хороон дээр бас төсвөө танилцуулж байгаа учир кабинетын өөр гишүүнээр тэгвэл танилцуулга уншуулъя. Учрал сайд танилцуулгыг уншиж танилцуулъя.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ. ЗГ-аас эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж, экспортыг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж, иргэдийн бодит орлогыг хамгаалахад чиглэсэн бодлого арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. ЗГ-аас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд улсын эдийн засаг сайжирч улмаар урт хугацааны хөгжлийн эхний 10 жилийн зорилт болох шинэ сэргэлтийн бодлогоо хэрэгжүүлэх боломж бүрдээд байна.

Тиймээс шинэ сэргэлтийн бодлогын гол зорилтын нэг болох хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжихэд чиглэсэн төсөв санхүүгийн багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2024 оны төсвийн төсөлд тусгасан болно. Ирэх оны төсөвт Монгол Улсын хууль зүй, дотоод хэргийн салбарыг бэхжүүлэх чиглэлээр тусгасан арга хэмжээнээс дурдвал. 1. Төрийн албан

хаагчийн цалинг нэмэгдүүлж, тэдэнд орон нутгийн нэмэгдэл олгох, 2-т хууль сахиулах байгууллагын үүрэг гүйцэтгэх бэлэн байдал болон аюулгүй байдлын чадавхыг бэхжүүлэх. *Офицер, ахлагч, хугацаат болон гэрээт цэргийн албан хаагчдыг дүрэмт хувцас хэрэглэлээр хангах, хоол хүнс, шатах тослох материал, хээрийн дадлага сургуулилт, машин техник хэрэгслийн засвар үйлчилгээ болон шаардлагатай зардлыг холбогдох хууль тогтоомж эрх зүйн актуудад заасны дагуу хуваарилах.* 3.Хилийн боомтуудыг нэвтрэх хүчин чадлыг нь нэмэгдүүлэх зорилтын хүрээнд агаарын замын хил. Дэглий цагаан авто замын хилийн боомт, Цагаан дэл уул, Бичигт, Боршоо, Бургастай, Алтанбулаг, Замын-Үүд, төмөр замын хилийн боомт, Шивээ хүрэн, Гашиун сухайтын орон тоо холбогдох төсвийг тусгах. 4-д орон нутгийн шүүхийн шинжилгээний байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа албан хаагчид 5 жил тутамд нэг удаа 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгох болон шинжилгээний лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай зардлыг шийд шийдвэрлэх. 5-д Монгол Улсын иргэдэд олгох иргэний үнэмлэх хэвлэх болон гадаад паспортын бэлдэц бэлтгэхэд шаардлагатай зардлыг нэмэгдүүлэх. 6.Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан, ил тод, нээлттэй байдлыг хангах, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, шүүхийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй ажиллах нөхцөлөөр хангахад шаардлагатай орон тоо, урсгал зардлыг тусгах. 7.Прокурор, авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагаа болон мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлж хөгжүүлэх зэрэг арга хэмжээний зардлыг тооцож тусгуулаад байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Ирэх 2024 оны төсөв санхүүгийн бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засгийн

өсөлт 7 хувьд хүрч, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25,3 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага 27,4 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал 2,1 их наяд төгрөг буюу ДНБ-ий 2,8 хувь болж, төсвийн тусгай шаардлага хангагдаж байгаа болно. Иймд ирэх оны төсвийн төсөлд хууль зүйн салбарын үйл ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр тусгасан арга хэмжээтэй танилцаж, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Танилцуулж дуусчав уу? Тэгвэл Монгол Улсын юу төсвийн, би нөгөө ажлын хэсгээ танилцуулна тийм үү? Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Цэвэгсүрэнгийн Наранчимэг танилцуулна. Наранчимэг 1 дүгээр микрофон өгье.

Ц.Наранчимэг: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллагаас Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7 болон Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь заалтыг үндэслэсэн Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд аудит хийж, дүгнэлт гаргалаа.

Монгол Улсын ЗГ-аас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг арвилан хэмнэлтэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн хэсгийг 7 зорилтын хүрээнд хянаж, үнэлэхэд аудитын зорилго чиглэлээ. Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг Улсын

Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан дараах шаардлагад нийцсэн гэж дүгнэж байна. ЗГ-аас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл нь Монгол Улсыг Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн бодлоготой нийцэж байна. Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25 их наяд 289,8 тэрбум төгрөг ДНБ-ий 34,2 хувь, нийт зарлага 27 их наяд 360,5 тэрбум төгрөг ДНБ-ий 37 хувь, тэнцвэржүүлсэн тэнцэл 2 их наяд 70,8 тэрбум төгрөгийн алдагдалтай ДНБ-ий -2,8 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ.

Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг боловсруулахад улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан дараах зорилт, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төсөвлөсөн байна. Шинэ сэргэлтийн бодлогод тусгасан хот хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, экспортыг дэмжих, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг эрчимжүүлэх, иргэдийн орлогыг хамгаалж, цалин, тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх хөгжилд суурилсан хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, иргэд, эх орондоо оношлогдон эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг хөнджээ.

Монгол Улсын ЗГ-ын 2020 он 24 оны төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв нь 2023 оны тодотгосон төсвөөс 275,6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 1 их наяд 767,5 тэрбум төгрөгөөр төсөвлөгдсөн нь ЗГ-аас 2024 онд нийт албан хаагчдын үндсэн цалинг 10 хувиар нэмэгдүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны ажлын хүрээнд улсын хилийг хамгаалах Монгол Оросын хамтарсан ажлын хэсгийн зардлыг

төлөвлөсөн. Улсын хил дээр алба хааж байгаа хилчний гэр бүлийн гишүүдэд ажилгүй байгаа хугацааны тэтгэмжийг олгох, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндэсний аюулгүй байдлын бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг тусгасан байна. Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр нь Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-ээс 2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго, зорилттой нийцэж буй хэдий ч Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээнээс ХЗДХ-ийн сайд дараах 2 арга хэмжээг тусгаагүй байна. Хаягийн мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх судалгааны үр дүнд бий болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, патентыг эдийн засгийн эргэлтэд оруулах. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах байр байгуулах, шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагаанд ISO9001, ISO1725 -ыг олон улсын стандартыг шинжилгээний лабораториудыг магадлан итгэмжлүүлэх эдгээр арга хэмжээг тусгаагүй байна.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 оны төсвийн багцад 212,6 тэрбум төгрөгийн 41 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төсөвлөснөөс жилийн төлөвлөгөөнд 177,5 тэрбум төгрөгийн 28 төсөл арга хэмжээ тусгагдсан, 35,2 тэрбум төгрөгийн 13 төсөл арга хэмжээ тусгаагаагүй байна. Үр дүнд чиглэсэн төсвийн төлөвлөлтийн аргыг улсын болон орон нутаг салбарын төсөвлөлтөд хэрэгжүүлснээс бий болох үр өгөөж, ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор хэмжих үзүүлэлтийг тодорхой болгож, хүрэх үр дүнг богино, дунд хугацаагаар тодорхойлж, үйл ажиллагааг хэмжсэнээр төсвийн зардлын ашиглалт, үр өгөөж нэмэгдэж, төлөвлөсөн хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх боломжтой байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-д Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд аудитаар дараах дүгнэлтийг танилцуулж байна. Төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн төслийг боловсруулахдаа хөтөлбөр бүрийн өртгийг тооцоогүй, арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тодорхойлоогүйгээс төсвийн зорилго хангагдах эсэхийг үнэлэх боломжгүй байна. Гадаад өрийн төсөвт үзүүлэх ачааллыг бууруулах зорилгоор дотоод үнэт цаас гарган төсвийн алдагдлын тодорхой эх үүсвэрийг бүрдүүлэхээр төсвийн төслийг боловсруулан боловч түүний үр ашгийг нарийвчлан тооцоолоогүй байна. Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр төсөвлөсөн төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн ангилалд магадлан хийгдэж байгаа 21, нэг маягаар болон жишиг магадлалтай 153 төсөл арга хэмжээг тусгасан байна. Барилга байгууламжид зураг төсөл, магадлал хийх, худалдан авах ажиллагаа зохион байгуулах гэрээ хийхдээ захиалагчийн хяналт болон гэрээний хэрэгжилтийг хангуулах, улсын комисс, барилга байгууламжийг хүлээж авах зэрэг төсвийн хөрөнгө оруулалтын үйл явцад тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулан субъектив сөрөг нөлөөллийг бууруулах эрх зүйн тодорхой нарийвчилсан зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэнд дараах асуудлыг толилуулж байна. Төсвийн төслийг хэлэлцэн батлахдаа Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг тухайн жилийн төсөвт тусгуулахад анхаарах шаардлагатай байна. Монгол Улсын ЗГ дараа оны төсвийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барихдаа төрийн аудитын байгууллагаас өгч буй дараах зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна. Төсвийн төсөл боловсруулах тухайн үед хүчин төгөлдөр

мөрдөж буй төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэсэн байх, Улсын хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн зөвхөн төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээг төсвийн төсөлд тусгаж байх. Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр Төсвийн хуульд тусгаж баталсан төсөл арга хэмжээний төсөвт өртгийн дүнд өөрчлөлт орж буй шалтгаан нөхцөлд нарийвчилсан судалгаа дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээг авч ажиллах.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төсөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх чиглэлийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгч, хэрэгжилтэд нь хяналт тавих. Хөгжлийн бодлогод нийцүүлсэн, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг бүрэн хэрэгжүүлж, салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан албан хаагчдыг нэгдсэн арга зүйгээр хангаж, чадавхыг сайжруулахыг зөвлөж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Энд Б.Жавхлан Сангийн сайд, С.Мөнгөнчимэг Сангийн дэд сайд, Ж.Ганбат Сангийн яамны ТНБД, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Г.Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Б.Сүх-Очир Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Ч.Чимидсүрэн Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, З.Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Э.Батмөнх Сангийн яамны Төсвийн хэлтсийн Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Б.Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Л.Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, С.Тулга Сангийн

яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Д.Отгонжаргал Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч, С.Гэлэгжунай Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн,

Аудитын ерөнхий газраас Ц.Наранчимэг Үндэсний аудитын газрын орлогч дарга, Я.Самбууням Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал тэргүүлэх аудитор, Д.Энхболд Гүйцэтгэл нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Л.Мөнхцацрал Аудит, нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын аудитын удирдлагын менежер, Х.Баярмаа Гүйцэтгэл нийцлийн аудитын газрын аудитын менежер, ШЕЗ-өөс Д.Зүмбэрэлхам ШЕЗ-ийн гишүүн, Р.Батрагчаа ШЕЗ-ийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга, ХЭҮК-оос Ц.Адъяахишиг ХЭҮК-ын Тамгын газрын дарга, Б.Бадамсэрээжид ХЭҮК-ын ахлах нягтлан бодогч, Монгол Улсын ҮХЦ-ээс Б.Баянбилэг ҮХЦ-ийн Тамгын газрын дарга, Б.Эрдэнэбат ҮХЦ-ийн ахлах нягтлан бодогч, Шүүхийн сахилгын хороо Д.Эрдэнэчулуун Шүүхийн сахилгын хорооны гишүүн, Д.Мөнхзориг Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга, Б.Ариунжаргал ерөнхий нягтлан бодогч, АТГ Г.Азжаргал АТГ-ын дэд дарга, З.Баасаньям АТГ-ын Тамгын газрын дарга, УЕПГ С.Гансэлэм УЕП-ын Хэрэг эрхлэх газрын дарга, орлогч прокурор, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын алба Л.Очирсүрэн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын албаны дарга, Г.Төгөлдөр Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн дарга,

Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа байгууллага Э.Энхтуяа ХЗДХЯ-ны нарийн бичгийн дарга, ХЗДХЯ-ны ТНБД, ТНБД-ын албан үүргийг түр орлон

гүйцэтгэгч бөгөөд Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Л.Нямгэрэл Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга, Д.Гантуяа ХЗДХЯ-ны Хөрөнгө оруулалтын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Г.Базаргүр ХЗДХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн хэлтсийн ахлах шинжээч, Д.Сүхболд ЦЕГ-ын дарга, цагдаагийн ерөнхий цагдаагийн хурандаа, Х.Лхагвасүрэн ХХЕГ-ын дарга, бригадын генерал, Б.Нандинболор ШШГЕГ-ын тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга, Д.Дэлгэрсайхан УБЕГ-ын дарга, Ж.Буянбат Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа, Н.Ууганбаяр ГИХГ-ын дарга, С.Энхбаатар Архивын ерөнхий газрын дарга, Х.Бат-Ирээдүй Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал, дэд хурандаа, П.Батбаатар Дотоод хэргийн их сургуулийн захирал, цагдаагийн хурандаа, Х.Эрдэм-Ундрах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, В.Оюумаа Хууль зүйн туслалцааны төвийн захирал, Г.Элбэгсайхан Оюуны өмчийн газрын дарга, П.Энхбаяр Мэдээллийн шуурхай удирдлагын төвийн дарга, цагдаагийн хурандаа, Н.Алтансүх ЦЕГ-ын ерөнхий нягтлан бодогч, Санхүүгийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа? Ц.Чойжилсүрэн ХХЕГ уу ийм ээ, Ц.Чойжилсүрэн ХХЕГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, хурандаа, Намсаманд ШШГЕГ-ын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын газрын дарга, хурандаа, Б.Өүлэн-Үжин УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга, Х.Саранчимэг Шүүх шинжилгээний ерөнхий газрын Санхүү хангамжийн газрын дарга, Ж.Солонго ГИХГ-ын Санхүүгийн хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч, Х.Цогтбаатар АЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга, Б.Оюунтөгс Төрийн тусгай албаны албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн Санхүү, хангамжийн албаны даргын үүргийг түр

орлон гүйцэтгэгч бөгөөд ахлах нягтлан бодогч, Ч.Лхагважав Дотоод хэргийн их сургуулийн Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга, хурандаа, Д.Урантуяа Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн ахлах нягтлан бодогч, Л.Болор-Эрдэнэ Хууль зүйн туслалцааны төвийн ахлах нягтлан бодогч, С.Содгэрэл Оюуны өмчийн газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга, Т.Алтанцэцэг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны Санхүүгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч, П.Доржготов Мэдээллийн шуурхай удирдлагын төвийн Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга, ингээд Хууль зүйн, ХЗБХ-ноос хариуцсан хэрэг референт Хулан оролцож байгаа болно.

Ингээд Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхий захирагч, захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд бас хүргүүлсэн байгаа. Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлтэй холбогдуулан төсөл санаачлагч болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуух гишүүн байна уу, нэрсээ өгнө үү. Раднаасэд гишүүнээр тасаллаа. Адьшаа гишүүнд микрофон өгье.

Ш.Адьшаа: Авлигатай тэмцэх төрийн болон төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудын сахилга хариуцлага ёс зүйн асуудлуудыг өнөөдөр бид олон түвшинд ярьж байгаа. Энэ үүрэг хариуцлагатай холбогдуулж энд ажиллаж байгаа төрийн тусгай болон төрийн жинхэнэ албан хаагчдын энэ цалин хангамжийн асуудлыг бид шийдэж байж энэ үүрэг хариуцлагын асуудлыг, ёс зүйн асуудлыг, үүргийн биелэлтийн асуудлыг ярих ёстой гэсэн ийм зарчим үйлчлэх ёстой гэж ингэж би бодож байна. Энд ХЗДХЯ болон Улсын Их Хурлын харьяа байгууллагын төсвийн тухай асуудлыг өнөөдөр бид ХЗБХ хэлэлцэж байна. Энэ шүүхийн тухай хууль

гэж байгаа. Энэ шүүхийн тухай хуульд Монгол Улсын ШЕЗ, Шүүхийн сахилгын хорооны болон шүүхийн төсвийг ХЗБХ-гоор баталж, Улсын Их Хуралд оруулдаг ийм хуулийн зохицуулалттай. Энэ зохицуулалтын дагуу ХЗБХ-гоор оруулсан төсөв хөрөнгө, ЗГ дээр танагдаж орж ирсэн байна. Энэ алиныг нь одоо бид баримталж энэ асуудлыг шийдэх вэ гэдэг талаар энэ нэг тодорхой хариулт өгмөөр байна гэж гэсэн ойлголт байна.

ХЗДХ-ийн сайдаас нэг асуулт асууя. Цагдаа хүчний байгууллагын хөрөнгө оруулалт, ажилчдын цалин хангамжийн асуудлыг бид өнөөдөр хэлэлцэж байна. Энд мөрдөх байгууллагын асуудал, мөрдөх байгууллагад ажилладаг мөрдөгч, гүйцэтгэх албаны хүмүүсийн цалин хангамжийн асуудлуудыг бид Улсын Их Хурал удаа дараа хэлэлцдэг. Энэ Тусгай хяналтын дэд хороогоор энэ бас хэлэлцдэг ийм журамтай хэдий ч би одоо тодорхой мэдээлэл судалгаа дээр үндэслэж энэ асуудлыг өнөөдөр зайлигүй тавих ёстой гэж бодож байна. АТГ-ын Мөрдөн шалгах алба, ТЕГ-ын мөрдөн шалгах алба, гүйцэтгэх албаны ажилтнуудын цалин хөлсний асуудал, цагдаагийн байгууллагын мөрдөх албаны ажилтан, гүйцэтгэх ажилтны цалин хангамж өнөөдөр тэмээ ямаа 2 шиг зөрөөтэй байна. Энд ямар бодлого явагддаг юм бэ? Би нийт цагдаагийн бие бүрэлдэхүүний тухай энд ярихыг хүсэхгүй байна. Зөвхөн өнөөдөр цагдаагийн байгууллагын мөрдөх алба, гүйцэтгэх албыг гүйцэтгэж байгаа хүмүүсийн цалин хангамжийг өнөөдөр яагаад ингэж ярихгүйгээр энэ ЗГ, энэ Улсын Их Хурал энэ бүрэн эрхийн хугацааг дуусгаж байна гэж ойлгож байгаа. Энэ салбарын сайдад нь байна уу, тухайн цагдаагийн удирдлагад нь байна уу аль эсхүл энэ цагдаа их муу ажилладаг юм уу?

Би цагдаа нарыг болбол бас нэг хамгийн их муу нэртэй ч гэсэн хамгийн их юмыг нь гүйцэтгэдэг хүмүүс байгаа шүү дээ. Цагдаа муу гэдэг, ард иргэд нь үзэн яддаг, нийгмийн сэтгэл зүй үзэн яддаг. Гэтэл өнөөдөр энэ хулгай луйвар, авлигал,

энэ муу муухай бүхнийг чинь цагдаагийн тэр гүйцэтгэх, мөрдөх албаны хүмүүс л гүйцэтгэдэг шүү дээ. Бид нар энэ хугацаанд энэ АТГ, онцгой, хил хамгаалах байгууллага, шүүхийн шийдвэрийн цалинг хэд хэдэн удаа нэмсэн. Гэтэл өнөөдөр энэ цагдаагийн байгууллагын энэ гүйцэтгэх, мөрдөх албаны цалинг яагаад ингэж нэмэхгүй ямар шалтгаан байна вэ? Сайд нь ийм санаачилга гаргахгүй байна уу аль эсхүл тухайн үеийн цагдаагийн удирдлага нь ийм ажилчдынхаа нийгмийн асуудал бусад юманд.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Эхний асуултыг Сангийн сайд, 2 дахь асуулт Хууль зүйн сайдаас асуулаа. Хууль зүйн сайд хариулах байх.

Б.Жавхлан: Адьшаа гишүүний асуултад хариулъя. Гишүүн тэгэхдээ асуултаа өөрөө сайн мэдэж байгаа байлгүй дээ. Зүгээр олон нийтэд би энэ асуудалд анхааруулж байгаа шүү л гэж юу болж байх шиг байна гэж би ойлголоо. Тэрнээс биш саяын таны хэлдэг энэ хүчний байгууллагуудын ялангуяа тусгай мөрдөх алба, гүйцэтгэх албаны цалин, урсгал зардал, хөрөнгө оруулалт бүх зүйл Тусгай хяналтын дэд хороогоор нууцын журмаар хэлэлцдэг байгаа шүү. Тийм учраас энд хэлэлцэх ямар ч боломж байхгүй. Сайд нь ч оруулж ирэх боломж байхгүй. Та хэлэлцэх шаардлагатай болбол Тусгай хяналтын дэд хорооны гишүүн болоод тийм хуралдаа орж суугаад, тэгээд тэнд хэлэлцээд явах боломжтой.

Д.Цогтбаатар: Хууль зүйн сайд хариулъя.

Б.Энхбаяр: Адьшаа гишүүндээ баярлалаа. Адьшаа гишүүн маань бас мөрдөн байцаагчийн ажлаас ажил амьдралын гараагаа эхэлж байсан хүн байдаг. Тийм учраас бас энэ цагдаа мөрдөгч нарын ажлыг их сайн ойлгож, цалинг нь нэмэгдүүлэх тал дээр бол байнга санаачилга гаргадаг гишүүний нэг байгаа. Яг өнгөрсөн жил төсөв хэлэлцэж байх үед бас таныг бас яг энэ асуудлыг

ярьж байсныг би санаж байна. Нэмэгдэх шаардлага бол байгаа. Ер нь ачааны хүндийг үүрдэг, гал усны фронтын тэргүүн эгнээнд байдаг, ард иргэд маань сайн сайхан үг хэлэхээсээ илүү нэг хэдхэн хүний бас үйлдлээр бүхэлд нь бас харлуулчих гээд байдаг хүнд хэцүү ажил байдаг. Амь нас, эрүүл мэнд гээд бүх л аюул осол тулгарахад хамгийн түрүүнд цагдааг л дууддаг. Тийм учраас би бол цагдаадаа баярлалаа гэдэг үгийг бол харамгүй хэлэх ёстой гэж, хэлдэг байх ёстой гэдэг ийм байр суурь дээр бол байдаг.

Цагдаагийн чиглэлд ч гэсэн бас нэлээн асуудлууд анхаарах шаардлагатай. Таны хэлсэнчлэн сүүлийн жилүүдэд тодорхой төрлийн гэмт хэргийн бас гаралтууд, зарим төрлийн гэмт хэрэг дээр ихсэж байна. Ачаалал ихсэж байна. Ялангуяа эрүүгийн төлөөлөгч, Улаанбаатар хотын тухайтад нийслэлийн дүүргүүд дэх эрүүгийн төлөөлөгч нарын хэргийн ачаалал огцом нэмэгдэж байна. Энэтэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүндрэл учирч байна. Улсын Их Хурлын 241 дүгээр тогтоолоор ноднин бас тодорхой асуудал шийдэгдсэн. Мэдээж АТГ гэдэг юм уу, прокурор гэдэг юм уу энэ байгууллагуудтай харьцуулах аргагүй том цар хүрээтэй. Тэр ч учраараа нэмэгдэх асуудал яригдвал далайц нь бол хамаагүй том яригдана. Саяын ярьж байгаа энэ АТГ-ын цалинтай бол харьцуулах бас хэрэггүй байх гэж бодож байна. Энэ бол тусдаа Улсын Их Хурлын бүтцийн байгууллага. Авлигатай ялангуяа сүүлийн үеийн авлигын гэмт хэргүүд бол их нарийсаж байна, улс үндэстэн дамнаж байна. Мөнгө угаалтын схем улам нарийсаж байна. Тийм учраас авлигатай тэмцэх байгууллагын бас хүн хүч, цалин мөнгөний асуудлыг сайжруулах гээд байгаагийн цаана юу ямар бодлого явж байна вэ гэхээр энэ нарийн төвөгтэй ээдрээтэй ялангуяа эдийн засгийн чиглэлийн ийм мэргэжсэн мэргэжилтнүүдийг татаж оруулах, зүгээр нэг Эрүүгийн хуулиар мэдсэн гэхээсээ илүүтэй өндөр түвшний

бэлтгэгдсэн ийм хүмүүсийг бас татаж ажиллуулах шаардлага байгаа нөхцөл бодит нөхцөл байдлаасаа хамаарч үүсэж байгаа юм. Энэтэй холбоотой асуудал би Байнгын хороонд танилцагдаж байгаа гэж үзэж байна. Тийм учраас нэг асуудлаар бол нөгөө асуудлыг нь харьцуулж цохилдуулах ийм боломжгүй байгууллагууд бас цар хүрээтэй ийм асуудлууд гэдгийг бол та ойлгож байгаа байх.

Тэгээд хулгайгаа цэгцэлчихвэл би эдийн засаг томорно гэж бодож байна. Эдийн засаг томорвол бид бас энэ бусад санаа чилээж байгаа, таны хөндөж байгаа жишээлбэл ганц цагдаа гэлтгүй бүх төрийн бас энэ нийтэд үйлчилдэг ажил албан хаагчдынхаа асуудлыг ч гэсэн бас энэ хүрээндээ багтаж шийдэх бололцоо бас гарах байх гэж бодож байгаа. ЗГ-аас ч гэсэн аль нэгийг нь онцлох гэхээсээ илүүтэй нийт төрийн албан хаагчдынхаа цалинг инфляцын түвшинтэй уялдуулж, тогтмол бас нэмж авч үздэг байх чиглэлээр Төсвийн хуулийн бодлогыг оруулж ирсэн байгаа.

Д.Цогтбаатар: Адъяаа гишүүнд нэмэлт асуух асуулт юу боломж өгье, микрофон өгье.

Ш.Адъяа: Энхбаяр сайдад баярлалаа. Бас ингээд цагдаагийнхаа энэ гүйцэтгэх, мөрдөх албаны цалин хөлсийг бас анхаарч ажиллах юм байна гэж ойлгож байгаа. Ер нь энд нэг нууц юм ерөөсөө яриагүй гэж ойлгож байгаа. Энэ цагдаа, гүйцэтгэх албаны тагнуул, АТ, эрүүгийн цагдаагийн хүмүүсийн цалин хөлс тийм нууц биш шүү дээ. Бид нар ямар энд нэг улсын нууц яриад, дэд хороогоор асуудал яриад байгаа биш, бодит амьдралыг л ярьж байгаа. Өнөөдөр авлигатай тэмцэнэ, төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлага, үүрэгжүүлэлт бид яриад байгаа. Гэтэл тэр ажиллах нөхцөл, нийгмийн асуудал, тэр хөрөнгө санхүүгийн асуудлыг зайлшгүй шийдэж байж бид өнөөдөр энэ шаардлага тавивал амьдрал дээр бодит асуудал шийдэгдэнэ, жинхэнэ авлигатай

тэмцэх эр зоригтой сэтгэл санаатай болно л гэж ингэж бодож байгаа юм.

Д.Цогтбаатар: Хариулт авч болсон уу? Тэгвэл Энх-Амгалан гишүүнд микрофон өгье.

Б.Энх-Амгалан: Би нэг тодорхой хэдхэн юм асуугаадахъя. Энэ Улаанбаатар хот дахь зарим зэвсэгт хүчний ангийг төвлөрсөн дулааны хангамжид холбох, дулааны эх үүсвэрээр хангахтай холбоотой зардлын нэмэгдэл зэргийг тооцож тусгасантай холбоотой 8,1 тэрбум төгрөг. Энэ Зэвсэгт хүчний ангиудыг бие даасан дэд бүтэцтэй болгож болоогүй юм уу? Заавал төвлөрсөн хангамжид холбоод л, тэгээд л тэрний нэмэгдсэн зардлыг нэмж тусгаад ингээд байх шаардлага байсан уу үгүй юү?

2 дахь нь алсын зайнаас уншигддаг чиптэй 300 мянган ширхэг иргэний үнэмлэх хэвлэх зардлыг тооцож тусгах гээд 26,7 тэрбум төгрөг дотор байна. Нэмээд 42,3 тэрбум төгрөгөөр 350 мянган ширхэг цахим гадаад паспорт, 50 мянган ширхэг энгийн гадаад паспортын бэлдэц бэлдэх энэ тэр гээд ийм шаардлага тийм амин чухал хэрэгцээтэй байгаа юу? Энийг нэг хариулаадхаарай.

Танай тэгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт дээр Хууль зүйн сайдын нийт хөрөнгө оруулалтын чинь 58,7 хувь нь тоног төхөөрөмжийн зардалд, 31,9 буюу бараг 32 хувь нь барилга байгууламжийн зардалд, тэгээд 11,1 тэрбум төгрөг нь их засварын зардалд гээд одоо ийм их олон барилга байгууламж бариад, засаад дотор нь тоног төхөөрөмжүүд аваад байх тийм шаардлага хэрэгцээ байна уу? Нийт төсвийн хөрөнгө оруулалтын чинь бараг 80, 90 хувь нь ийм зардалд явж байна шүү дээ. Энийг нэг асуугаадахъя.

Шүүхийн зардлаас, энэ томилолт зочны зардал нэмэгдсэн. Тийм учраас шүүхийн сургалт судалгааг нэмэгдүүлэх, зайн болон танхимын сургалтуудад хамруулах, сургагч багш бэлтгэх, ур

чадварыг дээшлүүлэх зорилгоор гадаад болон дотоод томилолтоор ажиллуулах төлөвлөсөн зардал гээд 347 тэрбум төгрөг байна. Тэрнийхээ яг доод талд дахиад 396,6 тэрбум төгрөгөөр шүүгчийн нэгдсэн сургалтын бодлогын хүрээнд сургалтын 70 хувийг хийнгээ суралцах, 20 хувь нь бусад оролцогчдоос суралцах, 10 хувь нь лекц контентоос суралцах арга зүйг нэвтрүүлэх, сургалтын үнэлгээний тайлан, сургалтын ажлыг сайжруулахад шаардлагатай зардал гээд ингээд орчихсон байгаа юм. Одоо ингээд шүүгч нар чинь контентоос суралцаад байх эсвэл зайнаас суралцаад байх ийм бололцоо боломж байдаг юм уу тийм ээ? Тэгээд ийм 2 зардал чинь давхцаад байгаа юм биш үү?

3 дахь зардал нь энэ АТГ-ын албан хаагчдын үндсэн цалинг 30 хувиар нэмсэн гэж байна. Орон тоог 20, 20 хүнээр нэмэгдүүлсэн гэж байна. Тэгээд энэтэй холбогдолтой 24 оны төсвийн төслөөр 45,8 тэрбум төгрөг байсныг 23 оны тодотгосон төсвөөс 38,2 хувиар өсгөсөн, 12,6 тэрбум төгрөгөөр өсгөсөн гэж байна. Ийм зайлиггүй шаардлага хэрэгцээ байгаа юм уу? Энэ тэгээд ямар зардлууд юм бэ яг? Энийг нэг тайлбарлаад өгөөч? Ийм 3 асуулт асууя. Яах вэ Хүний эрхийн Комиссын 3,1 хувиар л өссөн юм байна, АТГ-ын даргын төсөвт 2,6 тэрбум төгрөгийг тоног төхөөрөмжид зарцуулахаар тусгасан гэж байна. Энэ яг юу авах гэж байгаа юм бэ? Нэг ийм хэдэн зардалд хариулаадхаач.

Д.Цогтбаатар: Хууль зүйн сайд хариулах уу?

Б.Энхбаяр: Энх-Амгалан гишүүний асуултад манай тэр бэлдэцтэй холбоотой Дэлгэрсайхан бүртгэлийн дарга хариулна. Тэр хил хамгаалах байгууллагад хилийн заставууд чинь нөгөө дандаа төвлөрсөн шугамаас гадуур байгаа. Тийм учраас нөгөө төвлөрсөн шугамд холбогдоогүй байшингууд бариад байна гэдэг чинь манай хилийн салбар ангиудын л юмнууд яваад байгаа гэдгийг та ойлгож хүлээж аваарай.

Ер нь бол бага л асуувал зүгээр байна шүү. Ний нуугүй хэлэхэд би бол сайн танилцаж амжаагүй л явж байна. Тийм. Манай яам чинь ер нь санхүүгийн дарга ч байхгүй байна, төрийн нарийн ч байхгүй байна, бодлогын дарга ч байхгүй байна. Тэгээд гишүүд маань бас ойлгож бас бага асуувал их сайн байна. Нарийн юм асуувал шууд байгууллагынх нь дарга нараас нь асуучихвал их зүгээр байна гэж л хүсье дээ одоо.

Д.Цогтбаатар: Асуулт шүүхээс асуусан уу? Зүмбэрэллхам дарга хариулах уу тэгвэл? Та хариул, хэддүгээр микрофон байна вэ? 4 дүгээр микрофон дээр суучих, 4 дүгээр микрофон өгье.

УБЕГ-ын дарга Дэлгэрсайхан гишүүний асуултад хариулж байна. Иргэний үнэмлэх, гадаад паспорттой холбоотой асуулт асуулаа. Иргэний үнэмлэхийн хувьд бол жилдээ нэг ойролцоогоор 220 мянга, гадаад паспортын 360 мянгыг ерөнхийдөө дунджаар иргэддээ олгодог. Иргэний үнэмлэхийн хувьд бол ямар нэгэн цахим чип сайжирсантай холбоотойгоор тоог бол нэмэгдүүлээгүй. Тухайн сонгуулийн жилтэй холбоотойгоор иргэд бичиг баримтаа авах, илүү авах ийм жишгүүд байдаг учраас 50 мянгаар нэмсэн. Гадаад паспортын хувьд бол 2023 оны 3 дугаар сараас эхлээд цахим гадаад паспортыг иргэддээ олгож эхэлсэн. Өнөөдрийн хувьд бол цахим болон энгийн ийм гадаад паспортыг иргэд авах ийм бололцоо нэмэгдсэн учраас энэ 430 мянга болгож ийм нэмсэн байж байгаа. Яг өнөөдрийн байдлаар бид нар зөвхөн цахим гадаад паспортыг 3 сараас хойш олгож эхэлснээрээ яг энэ жилийн хувьд бол энэ 10 сарын байдлаар 400 мянга гаруйг бид нар бас олгочихсон байгаа юм. Тэгэхээрээ 2 шалтгаан байгаа. 1 дүгээрт бол цахим гадаад паспорттой болсонтой холбоотойгоор иргэд энэ паспортын тоо нэмэгдсэн, хоёрдугаарх нь энэ ковидын үетэй холбоотойгоор яг сүүлийн 2 жилүүдэд нь гадаад паспорт авах тоо

нэмэгдсэн учраас энэ 2 тоог бол нэмж оруулж ирсэн байгаа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Энх-Амгалан гишүүнд микрофон. Шүүхээс юу Зүмбэрэлхам дарга хариулах уу, хэн хариулах вэ шүүхээс? Шүүхээс хэн байна вэ? Дээд шүүхээс нэг ч хүн байхгүй байна гэж байна. АТГ-аас тэгвэл, 4 дүгээр, тэр микрофон харагдахгүй байна. 4 дүгээр микрофоныг өгье. Дэд дарга Азжаргал дарга хариулна.

Г.Азжаргал: Гишүүний асуултад хариулъя. Энэ АТГ-ын даргын төсөв дээр энэ 2,6 гэдэг нь энэ сая Их Хурлаас 23 албан хаагчийг орон тоог нь нэмсэн байж байгаа. Эдгээр албан хаагчдад зарим нь болбол 3 аймгийг хариуцаад мөрдөгч нар болбол хөдөө орон нутагт суудаг. Эдгээрийн ажиллах тоног төхөөрөмж, эдгээрт зориулагдаж байгаа.

Энэ цалингийн нэмэгдлийг болбол яах вэ 3 үндэслэл болбол байж байгаа. Нэгд нь болбол яах вэ энэ 2007 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр авлигатай Авлигын эсрэг хуулийг баталсан байдаг. Энэ дээр болбол төрийн бусад хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын цалингаас 50 хувь өндөр байх жишгийг баримталсан байдаг. 2 дахь үндэслэл нь болбол АТГ зөвхөн 2022 онд жишээ нь 2,3 их наяд төгрөгийг улсын төсөвт бодитоор яг оруулсан байж байгаа юм. 3-д нь болбол ер нь яах вэ энэ Авлигын эсрэг НҮБ-ын конвенцоор болбол яг энэ АТГ гэдэг болбол яг энэ уламжлалт байгууллага болбол бас биш. Яг энэ тусгайлсан зорилтот яг энэ авлигатай үзэгдэлтэй тэмцээд, тэгээд энэ болбол өөрөө тухайн үүргээ гүйцэтгэсний дараа болбол татан буугдах ёстой ийм ер нь болбол конвенцынхоо дагуу ийм байгууллага. Тэгэхээр болбол одоо тусгайлсан чиг үүрэгтэй ийм байгууллага байгаа.

Д.Цогтбаатар: Хариулт хангалттай юу Энх-Амгалан гишүүнээ? Тэгвэл Мөнхбаатар даргад юу микрофон өгье.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны гишүүдийн амрыг эрье. ХЗДХ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төсөв орж ирсэн байна. Урсгал зардал болоод хөрөнгө оруулалтын хувьд бас нэлээн боломжийн тавигдаад бас тулгамдсан олон асуудлуудаа бас шийдэж байгаа ийм төсөв харагдаж байна. Энэ дотор бас хэлэлцэгдэж байгаа нэг зүйл бол энэ шүүхийн төсвийн асуудал байгаа юм. Шүүхийн төсөв бол бас тусдаа дэгтэй ингээд явагддаг, өргөн баригдах, боловсруулах олон үе шаттай ингээд явагддаг ийм дэгтэй. Ер нь төрийн эрх мэдэл хуваарилах зарчим бол хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гээд 3 эрх мэдэлд бол хуваагдаж байгаа. Тийм учраас шүүхийн төсөв бол бие даасан төсөвтэй байна гэсэн ийм заалттай. Ийм учраас энэ төсвийг нь бол ХЗБХ-гоор урьдчилан хянаад, тэр хянагдсан төсвийг бол уул нь ЗГ бууруулахгүйгээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ийм үүрэг хүлээдэг. Энэ зарчмаараа явж байх ёстой. Энэ ч үүднээс нь өнгөрсөн хавар бас ХЗБХ-гоор ШЕЗ-ийн болоод Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгчийн төсвийг бол хянаад хүргүүлсэн.

Эндээс ингээд төсөвтэй танилцаад харж байхад бол юу харагдаж байна л даа. ХЗБХ-ноор хянагдсан төсөв маань эд нараас ШЕЗ өөрөө анх ирэхдээ 63 тэрбумын төсөв ирүүлсэн байна хөрөнгө оруулалтын төсөв дээр. Энэ дээр бол 42 тэрбумаар хянагдсан байгаа. Гэтэл энэ төсөв маань одоогийн орж ирж байгаа төсөв дээр ер нь хэрхэн яаж дууссан бэ? 42 тэрбум маань орж ирсэн үү? 42 тэрбум гэдэг маань өөрөө 3 дүүргийн байр, 4 аймгийн шүүхийн байр гэх мэтчилэн зүйлүүд байгаа. Энэ бол нэлээн томоохон хөрөнгө оруулалтууд бусад тоног төхөөрөмж болоод их засварын ажил гэсэн ийм л дүнтэй төсвүүд байгаад байгаа юм. Эдгээрийг нэг сонсьё. Хэрвээ орж ирээгүй байгаа болбол нь хууль зөрчсөн бас асуудал үүснэ. Тийм учраас энийг бол нэгэнт тогтсон жишиг учраас энэ цаашид ингээд аваад явах нь зүйтэй. Өнгөрсөн жил бол бас

тодорхой хэмжээгээр хасагдаж орж ирсэн. Түүнийг нь ажлын хэсэг дээр санал хураагаад яг ХЗБХ-ны хянасан түвшинд нь аваачаад явсан. Энэ бол ингээд сайн жишиг тогтоод байгаа юм. Тэгээд үүгээрээ цаашидаа явах нь зүйтэй.

Нөгөөтээгүүр ер нь үе үеийн л ХЗБХ-ны дарга нар очиж шүүхийн байртай, үйл ажиллагаатай танилцдаг. Би ч Хууль зүйн байнгын даргаар ажиллаж байх үедээ очсон. Энхбаяр дарга ч очиж танилцсан. Цогтбаатар дарга ч гэсэн сая очиж танилцаж байна лээ. Тэгээд нөхцөл байдлыг бол бүгд ойлгож. Тийм учраас энэ шүүхийн байр, шүүх үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр хангах асуудлаа бол Их Хурал гүйцэтгэх шаардлагатай. Одоо 70 байр шаардлага хангаагүй байранд үйл ажиллагаа явуулж байна гэж байна. 45 шүүх бол зөвлөлдөх тасалгаагүй байна гэж байна шүү дээ. Энэ бол шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд бол тулгамдаж байгаа, тулгарч байгаа том бэрхшээл болчихоод байна. Тэгээд энэ үүднээс нь энэ зүйл дээр анхаарал хандаж, энэ зүйлээ засаад явах нь зүйтэй гэж бодож байгаа. Тэгээд энэ тайлбарыг сонсьё.

Д.Цогтбаатар: Түрүүн бас Адьшаа гишүүн яг энэ чиглэлээр асуугаад байна лээ. Ер нь ингээд гишүүд энэ дээр онцгойлон бас анхаарч, энэ хууль зөрчигдөөд байгааг сануулж байна шүү. Энэ Сангийн сайд хариулах уу?

Б.Жавхлан: Гишүүний асуултад хариулъя. ХЗБХ-гоор төсөв нь хянагддаг байгууллагууд Улсын дээд шүүх, ШЕЗ, ХЭҮК, Шүүхийн сахилгын хороо гээд байгаа юм. Бусад өөр Байнгын хороодоор ч гэсэн төсөв нь хянагддаг, өөр өөрсдийн салбарын хуулиудаар орчихсон зүйлүүд байдаг юм. Гэхдээ ЗГ Монгол Улсын ирэх оныхоо төсвийг төлөвлөж оруулж ирэхдээ бид Төсвийн хуулиа барих бас үүрэгтэй. Төсвийн хуулиа барих үүрэгтэй. Бид энэ үүргийнхээ дагуу Монгол Улсын ирэх оныхоо төсвийг боломжит орлогодоо, эдийн засгийнхаа боломж хязгаартаа барьж тааруулж ингэж орж

ирдэг ийм байгаа. Тийм учраас ганц саяын дурдсан ерөнхийлөн захирагч нар ч биш, Монгол Улсын бүх ерөнхийлөн захирагч нараас 2024 онд нийтдээ 10 их наяд, 12 шүү, 12 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал, барилга байгууламж, тоног төхөөрөмж ийм санал ирсэн байдаг. Үүнийг 300 тэрбум төгрөг дотор л багтааж өргөн барих ийм хязгаар боломж нь улсын төсөв дээр байгаа юм. Жил бүр л ийм байдаг.

Ирүүлсэн саналууд дотор бид бас ажилласан, ажилласан. Урсгал зардал дээр болбол тун боломжийн хянагдсан байгаа. Хөрөнгийн зардлууд дээр болбол яах вэ бид нар энэ жил шүүхийн байгууллагууд гээд би яг нөгөө томоор нь юугаар нь хэлж байна шүү хэд хэдэн байгууллагаа хамруулаад. Эндээс ямар ч байсан бид Дээд шүүхийнхээ байрны асуудлыг болбол өмнө нь ярьж байсанчлан энэ жил болбол зохицуулалт хийгээд бүрэн шийдэж байгаа, засварыг нь ч шийдэж байгаа шинэ байрны. Мөн цахимжих би зарим нэг тоонуудыг нь дутуу хэлчихлээ шүү уучлаарай. Цахимжих зардлыг нь жишээ нь 10 хэдэн тэрбум байлаа даа, тэрбум төгрөгөөр 10 гаруй тэрбум төгрөгөөр бүтнээр нь тавьсан байгаа. Ийм байдлаар хөрөнгийн зардлууд нь тусгагдсан байгаа шүү. Ийм зарчмаараа, тэгээд тоонууд Чимидсүрэн дарга хэлээдэх үү.

Д.Цогтбаатар: Тодруулъя, хэн тодруулах вэ? Сангийн яамнаас 1 номерын микрофон өгье.

Ч.Чимидсүрэн: Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чимидсүрэн. Гишүүний асуултад хариулъя. Хөрөнгө оруулалтын хувьд болбол нэлээд тийм орон нутгийн шинжтэй тийм шүүхийн барилгуудын санал ирсэн байгаа. Тухайлбал Архангай аймгийн шүүхийн барилга, Багануур, Дархан-Уул, Дундговь, Завхан, Налайх, Өмнөговь эд нар гээд. Тэгээд эдгээрийг бас төсвийн орон зайны хувьд болбол энэ оны төсөвт болбол өргөн барьсан төсөвт бол суулгаагүй байгаа.

Харин их засвар, тоног төхөөрөмж дээр болбол хөрөнгө оруулалтын зардлыг бол суулгасан байгаа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Мөнхбаатар гишүүний микрофоныг өгье.

Л.Мөнхбаатар: Хариултуудаас харахад бол энэ хянагдсан төсөв тэр хүрээндээ бол орж ирээгүй гэдгийг бол хэлж байна. Тийм учраас би ХЗБХ-н дарга Цогтбаатар даргад хэлэх гэж байгаа юм. Энэ асуудал ер нь бол ингээд нэгэнт тогтсон жишиг, ХЗБХ-гоор яах гэж хянах гэж, хянана нь гэсэн хууль хийсэн юм. Тэр хянагдсан түвшиндээ жил бүр бариулж байх энэ жишигээ бол авч явах нь зүйтэй. Тийм учраас та энэ дээр бас санал хураалтаа зохион байгуулж явуулаад, хуулийн хэрэгжилтийг хангах нь зүйтэй шүү гэдгийг Танд хандаад хэлчихье.

Д.Цогтбаатар: Тэгвэл зарчмын зөрөөтэй санал гаргах хэрэгтэй болж байна шүү дээ. Мөнхбаатар дарга тэгвэл өөрөө зарчмын зөрөөтэй саналаа, би гаргаад явчихна гэж үү. Сангийн сайд энэ чинь тэгэхээр зарчмын, та тайлбар хэлэх үү?

Б.Жавхлан: Сүүлийн жилүүдэд ингээд жил болгон л энэ тайлбарыг хэлдэг юм. Би одоо дахиад хэлэхээс өөр аргагүй л болж байгаа юм. Бид энд хууль зөрчсөн зүйл төсөв талаас, ЗГ талаас бол огт байхгүй шүү гэдгийг би дахин, дахин хэлэх гэсэн, хэлэх гээд л байгаа юм. Төсвийн тухай хуулийн 3.4 дээр төсвийн харилцааг зөвхөн энэ хуулиар зохицуулна л гээд заачихсан байгаа. Шүүхийн аль ч байгууллага татвар төлөгчдийн мөнгөөр урсгал болон хөрөнгийн зардлаа санхүүжүүлдэг төсвийн байгууллага, бусад төрийн албан хаагч нар, төсвийн байгууллагуудад яг нэг ижил зарчмаар бас санхүүжигдээд явдаг. Хэрвээ бусад байгууллагууд хэрэв ингээд өөр өөрсдийнхөө салбарын хуулиуд дээр ингээд явах юм болбол Монгол Улсын төсвийг нэгдсэн байдлаар ЗГ хийх ямар ч

шаардлага хэрэгцээ байхгүй болно. Тэгэхээр тэр бас өөрийн.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Сангийн сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Тэгэхээр яг салбарын хуулиа, салбар салбарын хуулиа бариад ингэх юм болбол төсөв батлах маш хүндрэлтэй болж ирнэ. Бид шүүхийн байгууллагуудаас ирсэн саналууд огт тусаагүй биш. Жишээ нь урсгал зардал 157 тэрбумаар ирснийг 153-аар л хянасан байгаа. Бусад төсвийн байгууллагуудын хянасан дүнг харах юм болбол бүүр уйлмаар уйлмаар тоонууд байгаа шүү дээ. 157-гоос 4 тэрбум гэдэг бол энэ 2 хувь ч хүрэхгүй. Урсгал зардал бол хангалттай. Энэ дотор бол цахимжих зардлууд бол бүтнээрээ суусан байгаа шүү, бүтнээрээ суусан байгаа. Би Энхбаяр даргад Энхбаяр сайдад юу гэж хэлж байгаа вэ гэхээр шинэ хуулийн орчин бий болсон. Ингээд шинэ шүүхүүд байгуулагдана дүүрэг ингээд бүсчлээд. Яг тэр хөтөлбөртэйгөө холбогдуулаад нэг 3-аас 4 жил дамжаад хэдүүлээ ийм хөтөлбөр хийгээд 1 далайлтаар биш ингээд нэг дунд хугацаанд энэ асуудлаа шийдээд явъя.

Тийм учраас ирэх оных дээр бол бүтнээрээ энэ орж ирсэн дүнгээрээ болбол суух ямар ч боломжгүй шүү гээд. Төсөвт өртөг нь хэд билээ тэр манай Чимидсүрэн яасан муу мэдээ өгдөг юм бэ. Нийт төсөвт өртөг нь хэд билээ? 200, үгүй ээ тэгээд наадах чинь асаагүй байна, наанаа хэлчих. 270, төсөвт өртөг нь? Санхүүжих дүнг нь хэд гэж тавьсан байлаа. Тийм, тийм дүнгээр бол бүтнээр нь орж ирж байгаа нөгөө шинэ яг хуулийнхаа орчинтой зохицож байна уу үгүй юу гээд бас эргэж харах асуудлууд ч байгаа юм байна лээ. Тийм учраас энийг ингээд ярилцаж байгаад нэг дунд хугацаанд бүх асуудлаа шийдээд ингээд явъя гэж байгаа юм.

Өөр нэг зарчмын юм хэлэхэд би жишээ нь ШЕЗ-ийнхөнтэй энэ төсөв төсвийн дараа хэд хэдэн удаа уулзсан. Төсвийн асуудлаар. Одоо бүүр аргаа

бараад тэмдэгтийн хураамжаа нэмээд, тэгээд сан байгуулаад эндээсээ тэр хөрөнгө оруулалт болон бусад нийгмийн асуудлаа шийдээд явдаг байя энэ тэр гээд ийм саналууд хүртэл яригдсан. Тэгээд ингэж бол боломгүй л дээ. Төр байгаа цагт энэ шүүхийнхээ бие даасан байдлыг бүрэн хангаж, ажиллах цалин хөлс болон урсгал хөрөнгө оруулалтын бүх нөхцөлөөр нь бид хангаж өгөх ёстой ЗГ. Тийм учраас бид нар энэ зарчмаа бол бариад явна. Энэ удаагийн хөрөнгө оруулалтын зардал болбол бүтнээрээ суух ийм боломжгүй байсан гэдгийг л хэлэх гэж байгаа юм. Цаашидаа болбол ямар ч байсан бид нар урсгал зардал дээрээ үлгэр жишээ харуулаа шүү дээ. Ингээд 98 хувиар нь хянагдаж орж ирж байгаа. Тийм учраас цаашидаа болбол шүүхийгээ аль болох зовоолгүй цалинг нь ч хангалттай тавиад, байшин савыг нь ч үлгэр жишээ ингээд нэг хүний нүүр харахгүй ийм байдлаар явуулчих юм сан гэж ЗГ хичээж ажиллах л ёстой гэж хардаг.

Д.Цогтбаатар: Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: 2, 3 тодруулах зүйл байна. 24 онд шинэ хууль хэрэгжинэ. Нөгөө согтууруулах ундаа хэрэглэсэн жолооч гэмт хэрэгт тооцогдож байгаа, энэ хорих байгууллагын чинь хүчин чадал хүрэх үү? Тэрэн дээр энэ төсөвтэй холбоотой юм байгаа юу 1 дүгээрт.

2 дугаарт энэ үе үеийн энэ хэлэлцэх асуудал дотор хавар, намрын чуулган дээр байнга бичигдээд яваад байдаг энэ шүүхийн Шүүх шинээр байгуулах тухай асуудлууд яваад байдаг. Энэ шүүхийнхээ ачааллыг тэнцвэржүүлэх юмаа хэзээ оруулж ирэх вэ? Дагнасан болон энэ тойргийн чиглэлтэй шүүхүүдээ хэзээ байгуулах вэ, энэ чинь энэ төсөв дээр суусан уу? Сая өнгөрсөн хавар бид нар бас намрын, энэ намрын чуулганы хэлэлцэх асуудал дотор хийгээд баталсан. Одоо энэ дахиад бас байхгүй байдаг.

3 дугаарт энэ хууль хүчний байгууллага, ер нь цэрэг, цагдаагийн

байгууллагын албан хаагчдын цалин хөлс их муу байгаагаас хамаарч ажлаасаа олноороо гарч байгаа. Одоо бие бүрэлдэхүүний яг хэдэн хувьтай ажиллаж байна вэ? Энэ ерөөсөө цалинтай шууд холбоотой. Бид сая инфляцтай холбоотой 10 хувь гээд нэмэгдэж байгаа, орон нутгийн 20 хувь гэдэг бол тусгай албаныхан дээр, төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлж байгаа байгууллагууд дээр алин дээр нь ч ороогүй. 70 хувь, 60 хувь, 80 хувь зарим нь бараг 50, 50 хувьтай ч бүүр бүрэлдэхүүн дутуу ажиллаж байгаа. Энэ албан хаагчдын цалин хангамжийг сайжруулах талаар шинэ бодлогын юм хийж оруулахгүй болбол энэ яваандаа Монгол Улс хил манах цэрэг хилчингүй, цэрэггүй, цагдаагүй болох вий. Яагаад гэвэл уул уурхайн салбар болоод бусад энэ цалин хөлс өндөртэй салбар луу энэ залуучууд шилжиж байна. Цалингийнхаа зээлээр орон сууцын 30 хувиа түрүүлээд төлөөд орох боломж бололцоо энэ нөхдүүд хүмүүст байхгүй. Тэнд сарын хамгийн багадаа 5-аас 6 сая төгрөгийн цалин өгөхөд тийшээ явна. Одоо хилээр ойролцоогоор өдөрт 2400, 500 орчим ашигт малтмалын бүтээгдэхүүн хилээр гарч байгаа машин. Тэгээд 1 машины жолооч дунджаар гарахад 3 сая төгрөг хамгийн багадаа авч байгаа. Сардаа унтаж, унтаж байгаад 2 гарахад энэ хүн 6 сая төгрөгийн цалинтай.

Тэгээд энэ уул уурхайн компаниуд чинь хариуцлагатай цэрэг, цагдаагийн байгууллагад ажиллаж байсан архи дарс уудаггүй, ажилдаа хариуцлагатай ханддаг энэ хүмүүсийг нь түрүүлж авна. Ингэхээр тэр хүмүүс чинь амьдралын эрхээр тэр чиглэл рүү явж таарч байгаа юм. Тэгээд энэ цалин хөлсний бодлогоо бид нар нэг энэ байгууллага бүрээр нь ингэж ярих биш, цогцоор нь нэг томоор нь ярихгүй болбол энэ хууль хүчний байгууллагууд, цэрэг цагдаа, энэ зэвсэгт хүчин ч бас энэ дотор орж ирэх ёстой. Энэ байгууллагуудын алба хаагч бүрэлдэхүүн их суларна даа. Одоо ч суларчихсан байгаа, одоо илүү цаашаа энэнээс цаашаа сулрах байх. Юмны үнэ өсөөд байдаг, байрны үнэ өсөөд байдаг,

дагаад авч байгаа орлого нэмэгддэггүй. Тийм учраас энэ дээр яг энэ Хууль зүйн яамны асуудал уу, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны асуудал уу ямар ч байсан нийлж байж энэ дээр нэг тоймтой тодорхой бодлогууд энэ цалинтай холбоотой хөшүүргийн юмыг нь жсоохон урт хугацаанд нь хийж өгөхгүй болбол энэ цаашидаа энийг бид нар барьж дийлэхээ болино шүү. Дан сургууль төгссөн хүүхдүүдээр.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Минут нэмж авах уу? Раднаасэд гишүүнд 2 минут шууд нэмээд өгчихье.

Ш.Раднаасэд: Эхний нэг 2, 3 жил ажиллаад, тэрнээс цаашаа дан сургуульд ажлаасаа гараад өөр ажил руу шилждэг, дан залуучуудаар бүрдсэн туршилага дутуу ийм хүмүүсээр ийм бие бүрэлдэхүүн бүрдүүлэх юм болбол бүх салбар дээр алдаа байнга гарна. Байнга давтагдана. Тэгэхээр энэ цалинг нь яаж уях ёстой вэ? 5 жил тутам тэд биш, 6 жил болбол тэд, 7 жил болбол тэд гэж, ний нуугүй хэлэхэд бодит нөхцөл байдал өмнө нь болбол богино хугацаанд эрт тэтгэвэрт гардаг гэдгээрээ 36 сарын цалингийн тэтгэвэр авдаг гэдгээрээ эд нар хүмүүс маань жсоохон бусад албанаас илүү өөрсдийгөө барьж байсан байх албанд. Одоо болбол тийм боломж бололцоогүй байна л даа энэ хүмүүс. Амьдрахын тулд цалин орлого сайтай, хаана хамгийн өндөр цалин өгнө өөрийнх нь шаардлага шалгуур нь тэнцэж байгаа болбол тэр лүүхэн ч хамаагүй явж байна. Сая төгрөг, 2 сая төгрөгийн үнэтэй байсан байрны метр квадрат 3, 4 сая төгрөг гараад явчихлаа. Авдаг цалингийн хэмжээ 10, 20 хувь нэмэгдээд яах юм бэ. Тэгэхээр энэ дээр энэ Энхбаяр сайд энэ одоо нэг тодорхой энэ бүх цалингийн сангуудын нийлбэрүүд дээр нь, юунууд дээр нь хуулиудтай нь холбоотой нэг өөрчлөлтийг хийж бид нар оруулахгүй бол болохгүй. Их Хурлын гишүүд бол энэ тойргийн хэдэн сургууль, эмнэлэг, цэцэрлэг гэж ярьж суусаар байгаад энэ албан хаагчдын юуг болбол ерөнхийд нь хаяж байгаа шүү цалин хөлсний бодлогын юмыг. Ялангуяа энэ төрийн тусгай албан

дээр. Би бол батлан хамгаалах салбар хамгийн их байгаа, шүүхийн шийдвэр, хилийн цэрэг, цагдаа, жишээлбэл цагдаа бие бүрэлдэхүүн хэдэн хувь дутуу байна вэ? Мааш олноороо гадагшаа явж байгаа, мааш олноороо өндөр цалин дагаж явж байгаа.

Д.Цогтбаатар: Хууль зүйн сайд.

Б.Энхбаяр: Раднаасэд гишүүнд баярлалаа. Өнгөрсөн онд бас энэ асуудлыг хөндөж тавьж байсан. Ер нь хилээ манах энэ чинь манаачгүй болох нь байна шүү, хэв журмаа зохицуулах цагдаагүй болох нь байна шүү, хэргээ мөрдөх мөрдөгчгүй болох нь байна шүү гэдэг асуудал бас хөндөгдөж байсан. Улсын Их Хурал бас анхаарал хандуулж хил хамгаалах байгууллага, цагдаагийн байгууллагын албан хаагчдын цалинг энэ оны тухайд бол тус тодорхой хэмжээгээр нэмсэн. Энэ бол бас үр дүнгээ өгч байна. Үр дүнгээ өгч байна. Манай Хууль сахиулахын их сургуульд хилийн ангид нь оюутан элсэхгүй болчихсон байсан. Оюутнууд элсэхгүй болчихсон бүүр, элсэлт өгөх оюутан байхгүй. Яагаад гэхээр гараад угаасаа энэ нь бол цалин юм байхгүй ийм болчихсон. Мөрдөгч ялангуяа энэ ачаалал бүхий бас ялангуяа цагдаагийн албан хаагчдын тухайтад таны хэлж байгаа асуудал нэлээн бас хүндэрсэн. Сайн энийг чинь бас олон жил сургаж, тэгэхдээ татвар төлөгчдийн зардлаар бид сургаад, бэлтгээд, нэлээн бас цаг хугацаа хөрөнгө хүч зарж байж бэлддэг ажил шүү дээ. Тийм учраас энэ дээрээ бол үнэхээр анхаарал хандуулах шаардлага байгаа. Таны хэлсэнчлэн энэ асуудлыг бол цогцоор нь авч үзэх ёстой юм байна лээ.

Шүүх байгуулах тухай хуулийг ирэх долоо хоногийн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлнэ. Тэгээд Улсын Их Хуралд өргөн барина. 24 оны төсөвтэй шууд ухаалж уяхад бэрхшиэлтэй байсан. Шүүх байгуулах хуулийг яг хэрэгжүүлэх хүрээнд гарч ирэх нэмэлт ачаалал, төсвийн ачаалал бол 600 орчим тэрбум төгрөг гэсэн тооцоолол урьдчилсан байдлаар ШЕЗ дээр гарсан байгаа. Энэ асуудал

шүүх байгуулах хуулийн хүрээнд яригдана. Ганц жилийн дотор энэ нь хэрэгжихгүй. Тийм учраас бид шүүх байгуулах хуулийг 2026 оны 1 сарын 1-нээс үйлчлэхээр тооцоолж, бэлтгэл ажлыг хангаж, энд шаардлагатай хөрөнгө мөнгөний асуудлыг төсвийн бодлого дээр 2-оос 3 жилийн мөчлөгтэйгөөр хуваарилж байж үе шаттай шийдэх бодлогыг барихаар Улсын Их Хуралдаа ирэх долоо хоногоос танилцуулна. Ганцхан шүүхийн асуудал ярихад ийм том хэмжээний хөрөнгө яригдах учраас амаргүй л байна.

Хуучин бол 20 жилийн өмнө шүүгч болох бол хуульчдын, эрх зүйчдийн мөрөөдөл байсан. Энэ бол мөрөөдлийн ажил. Хуульч мэргэжлийн орой. Одоо ШЕЗ шүүгчийн орон тоон дээр орон тоо зарлаад хүн өрсөлдөхөө больчихоод байна шүү дээ. Жишээлбэл Хан-Уул дүүргийн иргэний шүүх дээр нэг жилийн хугацаанд зарлаад орон тоо нь бөглөгдөөгүй хэвээр байна. Энэ юу хэлж байна вэ гэхээр тийм өндөр ачаалалтайгаар, тийм өндөр ачаалалтайгаар, тийм цалингаар ажиллах тийм хүн олдохгүй байна. Энэ нь ямар үр дагавар луу түлхэж байна вэ гэхээр бид уг нь хамгийн сайн, хамгийн чадварлаг, хамгийн мундаг, хамгийн шударга хүнээ шүүгчээр залах ёстой. Энэ цалин хөлсний нөхцөл байдал энэ ахуйн нөхцөлийг нь шийдээгүйгээс болоод бид яг энэний эсрэгийг нь хүчээр сонгох байдал руу орж байна. Хамгийн сулыг нь, хамгийн чадваргүйг нь шүүгчээр томилох ийм урвуу хамаарал руу орж байна. Тийм учраас бид энэ шударга ёсны дархлаагаа хангахын тухайд сая Сангийн сайд хэлж байна. Шүүх эрх мэдлийн бүхэлд нь энд бол ЗГ онцгойлж анхаарна.

Д.Цогтбаатар: Хариулт хангалттай юу, одоохон хариулт юу? Жавхлан сайд энэ асуудалтай холбогдуулж нэмж хариулт хэлэх гэж байна уу?

Б.Жавхлан: Цогтбаатар даргаа ингэвэл яасан юм бэ, сая Энхбаяр сайд тайлбар аягүй ойлгомжтой хэллээ. Ирэх жилээс ингээд шинэ бид нар ийм хуулийн

зохицуулалт шаардлагатай болж ирж байгаа. Удахгүй ингээд өргөн баригдаад хэлэлцээд явах байх. Тийм учраас яг тэрэнтэй холбоотой байр тэр шинэ хөрөнгө оруулалтуудыг дунд хугацаандаа гээд бид одоо 24 оны төсөв баталж байна энэ бас мөчлөгийн сүүлийн жил гэсэн үг. Тэгэхээр өргөн барих хүртэл хугацаанд болбол цалинтай холбоотой асуудал болбол яригдаагүй шүү. Инфляцтай холбоотой нэмэгдэл болбол бүрэн тусгагдсан байгаа. Бусад өөр хуулийн байгууллагуудтай харьцуулаад ямар байна, ямар байх ёстой вэ тэрийг эргэж харах шаардлагатай байгаа бол энд мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас бас энэ цалин хөлсний холбоотой нэгдсэн бодлого тэнд зангидагддаг, тэндээс оролцоод, тэгээд бүгдээрээ Их Хурал дээрээ хэлэлцэх шатдаа ажлын хэсэг дээрээ ярилцаж байгаад, тэгээд өөр ямар боломжууд байна вэ тэгээд шийдвэл яасан юм бэ? Би цалинг нь хэлж байна шүү тийм, цалин хэлж байна. Хөрөнгө оруулалтууд бол боломжоороо суусан байгаа л гэж ойлгох хэрэгтэй. Засвар, цахимжих, цахимжуулах төсөл төсвүүд бүтнээрээ суусан.

Д.Цогтбаатар: Жавхлан сайдаа сая хил хамгаалах тухай яриад байна шүү дээ. Та өөр асуудал холиод яриад байх шиг байх юм. Ойлголоо Жавхлан сайдаа. Та түрүүн, асуусан тийм ээ, хариулт чинь хангалттай юу? Тэгвэл хэнээс хариултаа гүйцээж авах уу? Хууль зүйн сайд.

Б.Энхбаяр: Энэ нөгөө согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохыг гэмт хэрэгт тооцох асуудал бол Улсын Их Хурал хэлэлцэх эсэхийг нь дэмжчихсэн хууль эцэслэж бас л батлагдаагүй байгаа. Би батлагдаагүй хууль дээр урьдчилаад энэ асуудлыг хүмүүсийн шоронд хийх гэж байгаа гээд Улсын Их Хурал эцэслээгүй асуудал дээр бас яримааргүй байна. Мэдээж тодорхой хэмжээгээр энэ гаралт бол буурч таарна, ойлгомжтой. Шүүх юу юугүй л бүгдийг нь хориод байна гэж би бодохгүй байгаа. Торгох ял байна, зорчих эрх хязгаарлах байна, нийтэд тустай ажил хийлгэх ял байна. Үнэхээр

дүүрчихсэн давтагдашгүй тэгээд хүнийг яах вэ дээ дахин дахин тэгээд гээд байгаа хүнийг хорихоос өөр аргагүй шүү дээ. Тэрэн дээр л хэрэглэх болов уу гэж би бодож байна. Төсвийн хууль дээр бол 1 аравны, нэг зуугаад орон тоо, зуугаад орон тоо 1,6 тэрбум төгрөг.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Жавхлан сайдад микрофон өгье, юу тэрний дараа Энхбаяр сайд гүйцээгээд хариулах уу?

Б.Жавхлан: Уг нь сөрөг хүчин мэдээллүүдээ гүйцэд л авч байвал сайн биз дээ? Эсвэл дутуу авч байвал сайн юм уу, муу юм болгон сайн юм уу? Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын төсөв өнгөрсөн онтойгоо харьцуулах юм бол 104 тэрбумаас 142 тэрбум буюу 38,2 тэрбум төгрөгөөр бараг 40 хувь ингэж нэмэгдэж, төсөв нь өргөн баригдсан байгаа. Энэ дотроо ямар шалтгаанаар яаж нэмэгдсэн талаар дарга нь хариулна, задалж ярина биз шаардлагатай болбол. Тэр согтуу жолооч ч гэдэг юм уу, хоригдлууд нэмэгдэхтэй холбоотой зардал гэж би бас ойлгохгүй байна. Зүгээр энэ байгууллагын өөрийнх нь хүчин чадлыг нэмэгдүүлэх маш олон урсгал зардлууд байдаг. Хөрөнгө оруулалтууд ч байгаа. Энэ талаараа нэг сайхан дарга нь хариулна биз.

Ер нь манай хууль хүчний байгууллагуудын яг нэмэгдлийг ярих юм болбол энэ бусад салбарын төрийн албан хаагч нар ТЗ-ийнхэнтэй харьцуулахад хамгийн өндөр нь байдаг. Харьцуулшгүй өндөр шүү. Нийт цалингийн сан.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Бид нар эрх хязгаарлах, таслан сэргийлэх арга хэмжээ авах дээр 2024 онд гарах зардал дээр 100-гаад орон тоо, 1,6 тэрбум төгрөгийн зардал гарах юм байна гэдэг тооцоо хийгдсэн. Энийг 2024 оны батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэх боломжтой гэж үзэж байгаа. Цагдаагийн байгууллагын тухайд бол одоо 980 орон тоогоор дутуу байгаа буюу

нийт ажиллах ёстой орон тооны хязгаар, хязгаар дээр 9 хувь дутуу ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Д.Цогтбаатар: Ингээд асуулт асууж, хариулт өгч дууслаа. Тэгэхээр энэ дээр зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүд байна уу? Пүрэвдорж гишүүн зарчмын зөрөөтэй санал гаргаж байна уу? Үгүй ээ харин тэгээд гаргах болчихож байна л даа. Аль, аль. Зарчмын зөрүүтэй 2 санал орж ирж байна. Тэгэхээр зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя. Тодорхой төсөл, хөтөлбөр арга хэмжээний зардал нэмэгдүүлэх санал эсхүл татвар бууруулах санал гэдэг дээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын зардлаас 310 сая төгрөгөөр бууруулах, бусад төсөл, хөтөлбөр арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулах санал эсхүл зардал бууруулах санал гэж байна. Энэ дээр нь болохоор Хил хамгаалах ерөнхий газрын, хил хамгаалах салбарын их засварын зардлыг 310 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Байнгын хорооны, энд юу гэсэн байна вэ, би гаргахгүй байна. Энэ зөрүүлээд зарчмын саналаа зөрүүлээд биччихсэн байна гэсэн үг үү?

Тэгвэл би тэгээд зөвөөр нь уншихгүй бол болохгүй шүү дээ энэ чинь. Тийм. зөвөөр бичиж өгч байгаарай манайхан, бичсэнээр энд тэгэхгүй бол тэгээд дэндүү юу болчихож байна л даа, тийм. Тэгвэл тодорхой төсөл хөтөлбөр, арга хэмжээний зардал нэмэгдүүлэх санал эсхүл татвар бууруулах санал гэдэг дээр Хил хамгаалах ерөнхий газрын хил хамгаалах салбарын их засварын зардлыг 310 сая төгрөгөөр нэмэгдүүлэх тийм байна. Энэ яах аргагүй зөрүүлээд биччихсэн байгаа юм байна. Нөгөөдөх нь болохоор бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулах санал эсхүл зардал бууруулах гэдэг дээр болохоор Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын зардлаас 310 сая төгрөгөөр бууруулах гэсэн ийм саналыг Пүрэвдорж гишүүн дэвшүүлж байна. Энэ дээр, энэ дээр яасан ЗГ-аас тайлбар санал

өгөх үү? Тэгвэл Пүрэвдорж гишүүн үндэслэлээ тайлбарлах уу?

Б.Пүрэвдорж: 2016 онд дөнгөж шинэ гишүүн болчихоод энэ прокурорын цалин ер нь бол яах вэ Нямдорж сайд шүүхийн цалин өндөр байна гээд маш их шүүмжилж ярьдаг байсан. Тэгэхээр 16 оны, 17 оны төсөв ярьж байхад 16 онд энэ прокурорын цалинг нэмэгдүүлэх, Цэцийн цалинг нэмэгдүүлэх ийм санал гаргаад дэмжүүлээд өнөөдрийн Цэцийн гишүүд бол өндөр цалин авдаг болсон. Гэвч харамсалтай нь Цэц хэтэрхий их эрх баригчдын гар хөл болдог. Ямар ч Үндсэн хуульд хамааралгүй, ямар ч Үндсэн хуульд хамааралгүй асуудлыг Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэлт гаргадаг. Монголчуудын эрх ашгийн эсрэг ажилладаг ийм Цэц болж хувирсан байгаа. Тэгээд энэ Цэцийн урсгал зардал дээр нэг асуудал орж ирсэн. Өөрөөр хэлбэл урсгал шилжүүлэг дээр тэтгэвэрт гарах нэг удаагийн тэтгэмжийн зардлыг өсгөж төлөвлөөд тэрнээсээ болоод 247 сая төгрөгөөр жишээ нь үндэслэлгүй нэмэгдүүлсэн байх жишээтэй. Хэт өсгөж нэмэгдүүлсэн. Тэгээд энэ дүгнэлт нь шалтгааныг нь биччихсэн байна шүү дээ. Тэгээд дээрээс нь автомашин тээврийнхээ зардлуудыг үндэслэлгүй нэмж тусгасан, өсөлтийг тооцож нэмж тусгасан гээд ийм шалтгаанууд гаргачихсан байна.

Тийм учраас энэ 2 зардлыг нийлүүлээд 310 сая төгрөг гарч байгаа. Энэ 310 сая төгрөгөөр ҮХЦ-ийн зардлыг бууруулаад энэ хил дээр үнэхээр тэр хилийн хил манана гэдэг чинь бол үнэхээр хүнд хүчир ажил. Тийм хүнд хүчир ажлыг хийж яваа тэр хилчдийнхээ тэр амьдардаг орон сууц, тэр ажилладаг албан өрөөг нь засварлах шаардлагатай энэ мөнгийг гаргах нь зүйтэй гэж үзэж байна. Тийм тавьсан юм. Энэ үгүй ээ би хөдөө орон нутгаар наад хөдөө орон нутгаар явж байхад хүсэлт тавьсан. Хөдөө орон нутгаар явж байхад хүсэлт тавьсан. Тэгээд эрх баригчдад дэмжиж байгаа бол Цэц тэд нарын захиалагч нар гэсэн үг шүү.

Д.Цогтбаатар: Гэхдээ гишүүдээ эмоцио бариарай, энэ чинь ажил ярьж байгаа, төсөв хэлэлцэж байгаа учраас гишүүн байр сууриа хэлж байна шүү дээ бас. Сангийн сайдад яах юм тайлбар хэлэх юм уу? Тэгвэл ингээд эхний энэ зарчмын зөрүүтэй саналаар санал хураая. Энэ зарчмын зөрөөтэй санал дэмжигдсэнгүй.

Гэхдээ тийм 2 дахь санал бас Пүрэвдорж гишүүн гаргасан байгаа. Зарчмын зөрүүтэй санал уншиж танилцуулъя. Тодорхой төсөл хөтөлбөр, арга хэмжээний зардал нэмэгдүүлэх санал эсхүл татвар бууруулах санал ШЕЗ-ийн хөрөнгө оруулалтыг ХЗБХ-ны хянан хянасан төсвийг хэвээр нь үлдээж батлах буюу 52 уу, 58 аравны биш ээ энэ хэд байна вэ? 58,5 тэрбум төгрөгийн санхүүжилтийн дүнгээр нэмэгдүүлэх, бусад төсөл 55,8 ийм, бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулах санал эсхүл зардал бууруулах санал. Төсвийн төсөл дэх 9.1.3.1-д Сангийн сайдын юу санхүүжих дүн 36 тэрбум, 9.2.3.1 7 тэрбум, 9.2.3.2 9 тэрбум санхүүжих дүн тус тус бууруулахаар Пүрэвдорж гишүүн зарчмын зөрүүтэй санал оруулж байна. Үүгээр санал хураая. Сая ингэсэн байна. Яах аргагүй энд нөгөө бичиж өгөхдөө их тодорхой өгмөөр байна. Саяын саналыг юу хүчингүй болгох горимын санал оруулж байна. Яагаад гэхээр 52 тэрбум гэснийг энд яах аргагүй бичихдээ ингээд алдаатай биччихсэн, 58 гээд орчихсон байна. Тэгэхээр энэ 52 тэрбумаар Сангийн сайдын дүнгээс хасаж байгаа нь 52 байхгүй юу? Эндээ мөргөх ёстой шүү дээ. Хаанаа нэмж байгаа нөгөө талдаа хасаж байгаа нь. Тийм. Тэгэхээр та нар тэндээсээ ямар ч гэсэн энэ зарчмын зөрүүтэй ийм санал орж ирж байна шүү дээ. Харин тийм.

Тэгэхээр саяын харин буруу уншихсан учраас энэ саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал оруулж байна би. Ингээд санал хураалт. Тийм байна. Тэгвэл ингээд саяын юугаар санал хураагаад саналын дүн гарлаа. 2

санал хоёулаа дэмжигдсэнгүй. Тэгэхээр, ингээд сая зарчмын зөрүүтэй саналаар санал хурааж, 3 санал уу, 2 санал байсан юм шүү дээ. 3 санал та гаргасан уу? Үгүй шүү дээ, Үндсэн хуулийн чинь санал байна шүү дээ таны.

Ахиад тэгвэл саналын юу зарчмын зөрүүтэй санал байгаа юм байна. Пүрэвдорж гишүүнээс гаргаж байгаа. Тодорхой төсөл хөтөлбөр, арга хэмжээний зардал нэмэгдүүлэх санал эсхүл татвар бууруулах санал хууль зүй, дотоод хэргийн, ХЗДХЯ-ны 2024 оны төсвийн санал, төсвийн санал, юу гэж байгаа юм бол? Энд юу Пүрэвдорж гишүүнээ энэ юуг чинь би гаргадаггүй. Тэгье, Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Би энэ саналыг Энхбаяр сайдад бас тодорхой хэлсэн байгаа. Тэгээд ер нь бол ХЗДХЯ-ны 2024 оны хөрөнгө оруулалтын төсвийн санал ба салбарын барилга байгууламжийн их засварт 6,4 тэрбум төгрөг төсөвлөсөн байгаа. Тэгээд Гадаадын иргэн харьяатын газрын Баруун бүс дэх газрын үйлчилгээний барилгын нэмэлт ажлын төсөвт 423,8 сая төгрөгийн хуваарилуулах гээд. Энэ тэр 6 аравны дотор 4 дотроо энэ саналыг заавал тусгах ийм зохицуулалтын санал байгаа. Тэгээд сайдтай бол яг энэ асуудлаар бол ярилцаад тохирсон байгаа. Өөрөөр хэлбэл энэ ажил нь 4 км-ийн цаанаас л баахан юм хум татчихсан юм шиг байгаа юм. Уул нь өөр газар барьсан.

Д.Цогтбаатар: Сайд яах юм бэ, тайлбар хэлэх юм уу? Тэгвэл саяын уншсан зарчмын зөрүүтэй саналаар дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй 3 саналаар санал хурааж дууслаа.

Одоо ингээд би энэ дээр харин нэг хэдэн зүйл бас хэлчихье гэж бодож байна. Сангийн сайдад хандаад, Хууль зүйн сайдад бас хандаад нэг юм хэлчихмээр байна. Саяын шүүхийн холбогдолтой асуудал дээр нэг юм хэлмээр байна.

Сангийн сайдаа та Хууль зүйн байнгын хороон дээр орж ирж байгаа, тэгээд бид нарт хууль заагаад, хууль тайлбарлаад бас байж болохгүй. ХЗБХ-н дээр урьд нь гарсан шийдвэр юм байна лээ. Тэгээд энэ хуулиараа ХЗБХ-н дээр хянагдсан төсвийг бол засахгүй гэсэн хуультай юм байна лээ. Би ойлгож байгаа танайх Төсвийнхөө хуулийг барьж байгаа. Гэхдээ энэ дээр бол Монгол Улс эх газрын эрх зүйн тогтолцоотой орон. Тийм учраас Римийн эзэнт гүрнээс зонхилж ирсэн хууль зөрчиж байгаа тохиолдолд зохицуулдаг Максим байдаг. Тэрийг е... non derogant гэдэг. Төсвийн таны барьж байгаа хууль бол төсвийнхөө асуудлаар ерөнхий зохицуулалт юм. Яагаад гэвэл бүх салбарыг зохицуулж байгаа учраас. Энэ ХЗБХ-н дээр бид нар бүх салбарыг Батлан хамгаалах яамыг юм уу эсхүл Гадаад яамыг яриагүй. Хууль зүйн салбарын ялангуяа шүүхийн салбарын сая төсвийг ярьж байгаа юм. Тэгээд түүн дээр хууль зүйн, энэ хууль зүйн салбарын төсөв дээрээ энэ нь нарийвчилсан хууль. Энэ нарийвчилсан хууль нэг асуудлаар зөрчилдөж байгаа 2 хууль байх тохиолдолд нарийвчилсан хуулиа барьдаг зарчимтай. Өнөөдрийн хууль чинь ийм байгаа учраас би танд ямар ч гэсэн нэг бас юуг чиглэлийг өгмөөр байна. ХЗБХ-н даргын хувьд.

Төсвийн байнгын хороон дээр энийгээ багцлаад базаад орохдоо саяын энэ гишүүдийн ярьсан асуудлуудыг, ялангуяа ХЗБХ-ны өмнө гаргасан шийдвэрийг, тэрэнд нийцүүлсэн энэ засвар өөрчлөлтөө хийж оруулаарай. Яагаад гэвэл би бас энд хууль сануулмаар байна. ХЗБХ өөрөө хууль зөрчиж болохгүй. Тэр өмнөх гаргасан шийдвэр чинь хуультайгаа юу гаргасан шийдвэр өөрчлөгдөх ёсгүй юм байна лээ. Би тэрийг зохиогоогүй ийм л хуультай. Тэгэхээр энэ хуулийг та нар өөрчлөөд ороод ирчихсэн чинь хууль зөрчихсөн байгаад байгаа шүү. Тэгэхээр энийгээ засаж янзалж оруулахгүй бол энэ чинь эргээд хууль зөрчсөн асуудал болж, танай салбар дээр бууна шүү сайдаа. Тэгэхээр энийгээ та бас бодож юу Төсвийн байнгын хороон

дээр саналаа оруулахдаа энийгээ юу тусгаж оруулаарай гэж чиглэл өгмөөр байна. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё. Би бол цөөнхийн дуу хоолойнд бас хүндэтгэлтэй хандаж байгаа учраас санал, дүгнэлтийг нэгдсэн чуулганд Пүрэвдорж гишүүн, санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны хуралдаанд Пүрэвдорж гишүүн танилцуулна. Тэгвэл ингэе. Пүрэвдорж гишүүн тийм асуудалтай гэж үзэж байгаа бол ер нь бол Байнгын хорооноос чиглэл өгч болно шүү дээ. Та бол хууль зөрчихгүй юм байна лээ, тийм тэгвэл ингэе. Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулах Раднаасэд гишүүнийг томилж байна. Тэгье, тэгье.

18.42 цаг

Гурав. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа оръё. Манай гишүүд байж байгаарай, Пүрэвдорж гишүүнээ байж байгаарай, байж байгаарай, манайхан байж байгаарай. ЭХХШТХ-ийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулъя. Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын ЗГ-ын гишүүн, ХЗДХ-ийн сайд Баттөмөрийн Энхбаяр танилцуулна. Энхбаяр гишүүнд микрофоныг нь өгье.

Б.Энхбаяр: Компьютер дээр хэн сууж байна вэ, энд удирдлага нь ажиллахгүй байх юм. Алив компьютер дээр нь суугаад өгөөч, энэ юу удирдлага ажиллахгүй байна. Байнгын хороон дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас хүний халдашгүй чөлөөтэй байх Үндсэн хуульд

заасан үндсэн эрхийг хамгаалах, төрөөс зөрчихгүй байх, баталгаажуулах чиглэлээр ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа. Өнгөрсөн оны өнгөрсөн онд НҮБ-ын дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн дүгнэлт гарч, олон улсад танилцагдсан. Түүнчлэн ХЭҮК-ын 22 дахь илтгэлийг танилцаад энэтэй холбоотойгоор Улсын Их Хурлаас тогтоол гарсан байгаа. Тогтоолоор бол ер нь энэ хүний үндсэн халдашгүй чөлөөтэй байх үндсэн эрхэд гол халдаг хойшлуулиггүй баривчилгаа, цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний асуудлаар ер нь шүүхийн хяналтаас гадуур байна гэдэг асуудлууд их яригдсан. Тэр дотроо олон улсад бол манай улсын хойшлуулиггүй баривчилгааны 98-аас 99 хувь нь шүүхийн хяналтаас гадуур хийгддэг гэдэг ийм ноцтой мессеж өгөгдсөн.

Тийм учраас бид энэ асуудалд өөрсдийгөө хамгаалах зөвтгөх гэхээсээ илүүтэй яагаад, ямар үндэслэлээр ийм дүгнэлт өгчхөв гэдэг дээр нухацтай хандсан, судалгаа хийсэн. Судалгаа хийж авч үзэхэд сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан нийт баривчлах ажиллагааны 60-аас дээш хувийг хойшлуулиггүй тохиолдол гэдэг үндэслэлээр баривчилсан байна. Шүүхийн зөвшөөрөлгүй баривчлаад үргэлжлүүлэн цагдан хорьсон тохиолдол 2020 онд 448 буюу 56,4 хувь, 2021 онд 496 буюу 61,3 хувь, 2022 онд 595 буюу 55,5 хувийг тус тус эзэлж байна. Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа 2020 онд 798 хийгдсэнээс 178 буюу 22,3 хувь, 2021 онд 821 хийгдсэнээс 19,6 хувь нь шүүхээр хянагдсан байна гэдэг ийм дүгнэлт гарсан байгаа. Сүүлийн 8 жилийн хугацаанд нийт 238,7 мянган гэмт хэрэг бүртгэгдэж, бүртгэгдсэн гэмт хэрэгт 150 мянган хүн холбогдож шалгагдсан байна. Үүнээс 9261 сэжигтнийг хойшлуулиггүй баривчилсан байна. Энэ нь саяын хэлсэн гэмт хэрэгт шалгагдсан нийт хүний 9,2 хувь байна гэсэн ийм дүгнэлт гарч ирж байгаа юм.

Сэжигтнийг ямар хугацаагаар ер нь саатуулаад байна вэ гэдгийг авч үзэхэд 2016-аас 2023 оны 9 сарын байдлаар авч үзсэн байгаа. Дийлэнхдээ бол 48 цагийн хугацаагаар саатуулж байгаа юм байна гэдэг ийм дүгнэлт гарсан. Энэ 48 цаг хугацаагаар хойшлуулигүй баривчлаад энийгээ хэр зэрэг үргэлжлүүлж байна вэ эсвэл шууд суллаад байна уу гэдэг дээр мөн 2016 оноос хийгдсэн судалгааг та бүхэнд дэлгэцэд слайдаар харуулж өгсөн байна. Мэдээж цагдаагийн байгууллага дээр энэ асуудал дийлэнхдээ яригдана. Яагаад гэхээр АТГ болон тагнуулын байгууллагууд бол маш тодорхой хэргийн харьяалалтай холбоотойгоор энэ асуудлыг шалгадаг учраас нийт дүнгээрээ бол харьцангуй бага байгаа гэдгийг та бүхэнд хэлье. Гол асуудал бол энэ ямар хугацаагаар цагдан хориод байна вэ гэдэг асуудал байгаа. Нийтдээ бол 6 сар хүртэлх хугацаагаар цагдан хорьсон нь бол нийт цагдан хорионы 65 хувийг эзэлж байгаа. Өөрөөр хэлбэл 3 хүн тутмын 2 нь бол 6 сар хүртэл хугацаагаар цагдан хоригдож байна гэдэг ийм дүн гарсан. 35 хувь нь 1-ээс 3 сарын хугацаагаар цагдан хоригдож байна гэдэг ийм хугацааны асуудал гарсан.

Энэ дотор бол хамгийн гол асуудал бол энэ цагдан хоригдож таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүмүүс цаашаа шүүх рүү хэр шилжиж байна вэ гэдэг асуудлыг задалж судалж үзсэн. Яагаад гэхээр хэрвээ шүүх рүү шилжиж байгаа бол бид ер нь хүнээ олчихсон, зөв хүнээ таслан сэргийлэх арга хэмжээ авч цагдан хорьсон байна гэдэг үг. Хэрвээ шүүх рүүгээ шилжээгүй эргээд суллагдсан байх юм бол энэ нь бол бас гэм буруутай нь нотлогдоогүй бас хардаж сэрдэх ийм асуудал болжээ гэдгийн нотолгоо болж байна гэсэн үг. Энэ дээр 2016 оноос хойш авч үзэхэд бол би өөрөө ХЗДХ-ийн дэд сайдаар ажиллаж байх, ажиллаж яг үзээд дөнгөж томилогдоод 2016 оны 8 сард энэ статистикийг авч үзэж байхад цагдан хоригдсон хүмүүсээс цаашаа шүүх рүү шилжсэн нь аягүй цөөхөн байсан юм. 5 хүний нэг нь байсан тэр үед.

Ингээд ЭХХШТХ-д өөрчлөлт оруулъя, энэ цагдан хорих гэдэг чинь энэ ер нь ийм олноор нь ингээд түр саатуулаад, тэгээд шүүх рүүгээ шилжүүлэхгүй суллаад байна гэдэг бол их ноцтой асуудал байна гэж үзэж 2016 оны намар Улсын Их Хуралд өргөн барьж, 2017 оны 7 сарын 1-нээс үйлчилсэн ЭХХШТХ-аар цагдан хорих үндэслэлүүдийг харьцангуй объектив болгохыг эрмэлзсэн. Гэвч энэ дээр хууль хэрэгжсэн өнгөрсөн 5, 6 жилийн ингээд нөхцөл байдлыг авч үзэхэд гэмт хэрэг дахин үйлдэж болзошгүй, оргон зайлж болзошгүй гэдэг энэ 2 үндэслэлээр дийлэнх цагдан хориог хийсэн байна. Тэгэхээр энэ маань өөрөө субъектив үндэслэл байна гэж үзэж байгаа юм. Объектив биш. Хэн ч өөрөөр тайлбарлаж болох, барих барьцгүй ийм үндэслэл байгаа учраас ерөөсөө ийм цагдан хорих үндэслэл дээр субъектив үндэслэл бичихээс татгалзъя. Нэн тодорхой объектив буюу барих барьцтай нотлогдох ийм үндэслэлүүдийг бичихгүй болбол эргээд гэм зэмгүй хүмүүсийг цагдан хорьсон хорьдог асуудал бол хэвээр үргэлжлэх юм байна гэж үзэж, 4 маш тодорхой үндэслэлээр л цагдан хорих үндэслэлийг солихоор санал дэвшүүлж байгаа юм.

Та бүхэн харж байгаа 2023 оны 2017 оны ЭХХШТХ үйлчлэхэд 19, 20 онд цагдан хорио нэг нэмэгдэж ирээд энэнээс хойш тасралтгүй буурч байгаа. Өөрөөр хэлбэл 2020 оноос хойш цагдан хорьж шалгаж байгаа хүмүүсийн тоо эрс буурсан байгаа юм. Тухайлбал 2020 онд 1751 хүн дээр цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авч байсан бол 2023 оны 9 сарын байдлаар 965 болсон байна 965. 2022 оны тухайд 1389, 2021 онд 1291 гэсэн ийм дүн мэдээ гарч байгаа. Тийм учраас ер нь хорьж шалгадаг, цагдаж хорьж шалгадаг энэ тоо бол жил тутам буурч байгаа гэдгийг та бүхэн бол эндээс бол тодорхой харж болохоор байгаа юм.

Дараагийн хамгийн гол зарчмын асуудал бол сая хэлсэнчлэн 22 орчим хувь нь 48 цагийн хойшлуулигүй

баривчилгааны 22 орчим хувь нь л шүүхээр хянагдсан байна. Шүүхээр орсон. Тэгэхээр аливаа төрлийн хойшлуулиггүй баривчилгаа, цагдан хорих асуудал бол бүх 100 хувь шүүхийн хяналтад явагдах ийм хувилбарыг санал болгож байгаа юм 100 хувь. Шүүхийн зөвшөөрөл хяналтгүйгээр аливаа төрлийн хойшлуулиггүй баривчилгаа цагдан хорионы асуудлыг бол огт болж болохгүй гэж байгаа юм. Энэтэй холбоотой тодорхой процессын өөрчлөлтүүдийг оруулж ирж байгаа. Цагдан хорих хугацаа манай улсын тухайтад хөнгөн хэрэг дээр 12 сар байна дээд хугацаа. Өөрөөр хэлбэл 1-ээс 5 жилийн хорих ялтай, 1-ээс 5 жилийн хорих ялтай хөнгөн хэрэг дээр цагдан хорьж шалгаж байгаа хугацаа нэг жил байгаа байхгүй юу. Тэгээд энэ бол дэлхийн дунджаас 2 дахин өндөр байна. Хөнгөн хэрэг дээр цагдан хорьж байгаа хамгийн дээд талын хугацаа дэлхийн бусад улс орнууд дунджаар 6 сар байна. Тухайлбал, Герман, Франц, Япон бол бүүр 2 сар байна, Солонгос 2 сар байна, ОХУ 2 сар. Тэгэхэд манайх 12 сар гэж байна. Японоос 6 дахин өндөр, ОХУ-аас 6 дахин өндөр хугацаагаар цагдан хорьдог ийм улс болчихсон байна. Тийм учраас бид энэ хөнгөн хэрэг дээрх цагдан хорих хамгийн дээд хугацааг 6 сар болгоё гэж 2 дахин багасгая гэдэг ийм саналыг оруулж ирж байна.

Мөн энэтэйгээ холбоотойгоор 5 жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан хэрэг дээр цагдан хорих дээд хугацаа 18 сар байгааг 12 сараас хэтрүүлэхгүй, 8 жилээс дээш хугацаагаар ял ноогдуулахаар шийдэгдсэн хэрэг дээр цагдан хорих хугацаа 18 сараас хэтэрч болохгүй гэдгийг 18 сараар нь өөрөөр хэлбэл хуучны онц хүнд гэмт хэрэг дээр 18 сараар нь ганцхан үлдээхээр бусад бүх цагдан хорих дээд хугацаануудыг багасгахаар ингэж оруулж ирж байна. Энэтэй холбоотой прокурор болон шүүхийн процессыг оруулж ирсэн. Түүрүүн хэлсэнчлэн цагдан хорих үндэслэлийг мөн бичсэн. Цагдан хорих байранд гүйцэтгэх ажил хийдэг явдлыг хязгаарлая гэж байгаа юм. Хязгаарлаад дараах 5 төрлийн

хэрэг дээр л цагдан хорих байранд гүйцэтгэх ажил хийхийг зөвшөөрье. 1 дүгээрт бусдыг санаатай алах, хүчиндэх, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, авлигын гэмт хэрэг, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг, хар тамхи, мансууруулах бодисыг зохион байгуулалттайгаар бусдад худалдаалах гэсэн энэ төрлийн хэргүүд дээр л гүйцэтгэх ажлыг цагдан хорих байранд зөвшөөрье. Бусад аливаа бүх төрлийн хэрэг дээр шууд хаая гэдэг ийм саналыг дэвшүүлж байгаа юм.

Мөн сонгуулийн үйл ажиллагаатай холбоотойгоор Сонгуулийн хууль тогтоомж зөрчих асуудлуудыг бид 2020 онд тагнуулын байгууллагад харьяалуулж үзсэн. Тагнуулын байгууллага маань та бүхэн мэдэж байгаа улсын хэмжээнд явагдаж байгаа 7 мянга гаруй нэр дэвшигч оролцож байгаа ийм том хэмжээний сонгуулийн өдөр тутам болж байгаа хэдэн 10 мянган маргааныг хянах, шийдвэрлэх хүн хүч, зохион байгуулалтын нөөц бололцоо байхгүй. Тийм учраас цагдаагийн байгууллагад хуучин байснаар нь энэ хэргийн хэргийн харьяаллыг нь хариуцуулья гэдэг ийм хуулийн өөрчлөлтийг санал болгож байна.

Энэтэй холбоотойгоор яах вэ бид бас нэлээн хурдтай шуурхай ажиллах гэж байна гэж байгаад нэг асуудлыг орхичихсон байгаа. Хэлэлцүүлгийн шатад бас эрхэм гишүүд та бүхний нэг асуудлыг оруулж өгөөч гэж хүсэж байгаа. Тэр нь одоо цагдан хорих асуудлыг мөрдөгч, прокурор шууд шүүхэд танилцуулаад шийдвэр гаргаад байгаа. Нөгөө цагдан хоригдож байгаа этгээдийн этгээдэд үндэслэлийг нь танилцуулдаггүй, өмгөөлөгчид нь танилцуулдаггүй. Тэгтэл Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар өөрөө өөрийгөө өмгөөлөх, ямар хэрэгт буруутгагдаж байгаагаа мэдэх хууль зүйн туслалцаа авах үндсэн эрхтэй байгаад байгаа байхгүй юу. Энэ эрхийг нь цагдан хорих ажиллагаа дээр ерөөсөө харгалздаггүй ийм асуудал нутагшаад байна. Энийг залруулах, бид ярьж байгаад

энэ дээр нэг техникийн алдаа гараад, тэр хэсгээ хөндөөгүй орхиод ирчихсэн байна. Тэгэхдээ зүйлийг нь хөндчихсөн байгаа. Тийм учраас хэлэлцүүлгийн шатад бас эрхэм гишүүдийг энэ асуудлыг хөндөж, өмгөөлөгчид нь танилцуулах, өмгөөлөгчийг нь өөрийгөө мэтгэлцэх тэр бололцоог нь олгох чиглэлд бас бид томъёоллыг нь бэлдчихсэн байгаа. Энэ асуудлыг бас хэлэлцэхэд дэмжиж өгөөч гэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Энхбаяр сайдад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Энэ мөн үү, биш эрүү шүү дээ. Хууль зүйн ХЗДХ-ийн сайдын зөвлөх Дэмбэрэлцэрэнгийн Мөнх-Эрдэнэ, Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Батаагийн Батцэрэн, УЕП-ын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх Максимын Чинбат, УЕП-ын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Отгонбаярын Мөнхбаатар, ЧД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатын шүүхийн шүүгч Лхагвасүрэнгийн Галбадар, ХЭҮК-ын гишүүн Батзэвэгийн Энхболд, Эрүүгийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, боловсронгуй болгох чиг үүрэг бүхий Байнгын ажлын хэсгийн гишүүн Базаргүрийн Гантуяа гэсэн хүмүүс орж байна, өөр байна. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах, ШШГЕГ-ын Тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга Баярын Нандинболор, ЦЕГ-ын захиргаа, удирдлагын газар дарга Лхамдоржийн Нямдаваа, ЦЕГ-ын Экологийн цагдаагийн албаны дэд дарга, цагдаагийн хурандаа Баттөмөрийн Батсуурь, ТЕГ-ын Мөрдөн шалгах газрын дарга Дашийн Энхтөр, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Шагдарсүрэнгийн Цолмон, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Цэрэнсүрэнгийн Лхагвацэнд, Монголын хуульчдын холбооны гишүүн хуульч, доктор, дэд профессор Бадамын Батзориг, Монголын Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч Лхагвын

Данзанноров гэсэн хүмүүс оролцож байна.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү. Мөнхцэцэг гишүүнд микрофон өгье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр ХЗДХ-ийн сайдын оруулж ирж байгаа ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг үзэл баримтлалыг бол дэмжиж байна. Ер нь Монгол Улс дахь эрүүгийн бүх мөрдөн шалгах үйл ажиллагаа тэр дотор сэжигтнийг баривчлах энэ үйл ажиллагаа болбол хүний эрхийн суурь зарчмуудын дагуу явагдах ёстой. Тэгээд ер нь хүнийг, сэжигтнийг хүнийг баривчилна гэдэг бол Үндсэн хууль болон олон улсад заасан хүний халдашигүй чөлөөтэй байх эрхэд нь халдаж байгаа, эрх чөлөөг нь хязгаарлаж байгаа ийм ноцтой ажиллагаа учраас энэ дээр бол хуулийн болон хүний эрхийн зайлшгүй үндэслэлийг харгалзах ёстой. Тийм учраас энэ төсөл дээр бид нар хүний эрхийн үүднээс анхаарах шаардлагатай.

Тэгэхээр одоо үйлчилж байгаа ЭХХШТХ-ийн 31.4, 31.5-аар бол сэжигтнийг баривчлах 2 үндэслэлийг бол заасан байгаа. 1 дүгээрт нь шүүхийн зөвшөөрөлтэй болоод зөвшөөрөлгүй гэж. Тэгэхдээ энэ заалтууд маань манай хуульчид экспертүүд, мөн Монголын хүний эрхийн нөхцөл байдалд дүгнэлт гаргадаг олон улсын байгууллагуудын зүгээс бол нэлээн шүүмжлэлд өртдөг, үүнтэй бол би бол санал нэг байдаг. Тухайлбал сэжигтнийг баривчлах үйл ажиллагаа дахь эрх эрх мэдэлтэй албан тушаалтнуудад субъектив нөлөөлөл байх магадлалтай. Тэгээд зайлшгүй баривчлах үндэслэл нь хэт ерөнхий, зарим тохиолдолд энийг бас тухайн хүний субъектив хандлагаас болон ялгаатай байдлаар хэрэглэх ийм нөхцөлүүд байна гэсэн ийм дүгнэлт ийм зөвлөмжүүд байдаг. Энэ бол яах аргагүй түрүүн сайдын танилцуулгад гарч байгаа бараг баривчлагдсан хүмүүсийн 80 орчим хувьд нь болбол шүүхийн зөвшөөрөлгүй орж ирсэн байдаг. Тэгэхээр энэ дээр бол бид

нар зайлиггүй шинэчлэл хийх шаардлагатай.

Тэгээд нэг ийм асуулт байна. Ер нь энэ сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах энэ бүх үйл ажиллагаа болбол прокурорын хяналт доор явагдах ёстой. Энэ бол хууль, эрх зүйн заалтууд байгаа. Тэгээд ер нь прокурор бол энэ мөрдөн байцаах үйл ажиллагаа, сэжигтнийг баривчлах үйл ажиллагаанд хяналт тавьж, энд хүний эрхийн зөрчил гарах уу үгүй юү гэдгийг урьдчилан сэргийлэх ийм үүрэгтэй. Тэгэхээр шинээр оруулж ирж байгаа энэ ЭХХШТХ-ийн төсөлд прокурорын үүрэг, эрх хэмжээтэй холбоотой, энэ баривчлах процесс дахь прокурорын одоо оролцож байгаа энэ заалтуудыг сайжруулах буюу хүний эрхийн үүднээс ямар дэвшилттэй заалтууд оруулж байгаа вэ гэдгийг тодруулж асуумаар байна.

Д.Цогтбаатар: Хууль зүйн сайд хариулах уу? Хэддүгээр микрофон байна вэ? 5, харагдахгүй байна. 2 дугаар микрофон.

Б.Батцэрэн: Та бүхний энэ оройн амгаланг айлтгая. Тэгэхээр баривчлах цагдан хорих арга хэмжээ бол 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиас шүүхийн хяналтад орж ирсэн. Гэхдээ хэрэгжилтийг нь ингээд 2017 оны 7 сарын 1-нээс батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг судалж үзэхэд бол яах аргагүй баривчлах ажиллагаа бол 98, бараг 99 хувь нь шүүхийн зөвшөөрөлгүй буюу хойшлуулиггүй журмаар баривчилж байгаа юм. Энэ бол түрүүн Хууль зүйн сайдын хэлсэн НҮБ-ын ажлын хэсгийн дүгнэлт болоод ХЭҮК-ын илтгэлд бол тодорхой дурдагдсан, батлагдсан ийм тоо баримтууд. Тэгэхээр 1 дүгээрт баривчлах тэр хууль зүйн үндэслэл бол субъектив гэхээсээ илүү объектив шалгуур нь бол тодорхой байх ёстой. Нийт баривчилгааны 60 хувь нь бол хойшлуулиггүй журмаар гэдэг ийм жишжүүрийн үг тогтоолд бичээд ингээд баривчлах ажиллагаа явагдаж байгаа юм.

Гэтэл тэр хойшлуулиггүй ажиллагаа бол дотроо өөрөө яг ямар хойшлуулиггүй ажиллагаа юм бэ гэдэг нь бол тодорхой заагдсан байх ёстой. Тэгэхээр энэ нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд бол энэ баривчлах үндэслэлийг шүүхийн зөвшөөрөлгүй хойшлуулиггүй журмаар баривчлах 6 үндэслэлийг бол тэр объектив шалгуураар нь маш тодорхой хуульчилж өгсөн. Тэгээд мөрдөгч тэр тогтоол дээрээ яг ямар үндэслэлээр баривчилж байгаа туйлын тодорхой бичнэ, тэрийг нь прокурор хянана гэсэн үг. Тэгээд дараа нь энэ баривчлах ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдсан уу гэдэг дээр шүүхийн хяналтыг бас хэрэгжүүлнэ. Үүгээрээ бол тэр өмнөх шалгуур бол ийм объектив бодитой болсноор энэ бол нэг том дэвшил гарч байна гэж ингэж хэлж болно. Тэгээд энэ бүх ажиллагаанд бол прокурор хяналтаа тавих чиг үүрэгтэй. Тэр хуульд заасан үндэслэл байхгүй байхад эсвэл хуульд заасан журмыг зөрчиж баривчлах ажиллагаа явагдсан байх юм бол түүнийг суллах ийм үүрэг, эрх хэмжээ нь бол прокурорт хэвээр байгаа. Гэхдээ энэ 48 цагийн баривчлах ажиллагааг бол илүү нарийсгаад энэ 24 цагийн дотор баривчлах ажиллагаа эхэлснээс хойш энд прокурор хяналтаа бүрэн хэрэгжүүлнэ. Цаашид үргэлжлүүлэн цагдан хорих үндэслэл байгаа бол асуудлыг шүүх рүү шилжүүлнэ.

Тэгэхээр шүүх 1 дүгээрт одоо бол ингээд үргэлжлүүлэн баривчлах зөвшөөрөл олгож байгаа бол энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт орсны дараа бол энэ баривчлах үндэслэл байсан уу, баривчлах ажиллагаа хуулийн дагуу явагдсан уу гэдэг дээр заавал дүгнэлт хийнэ. Ингээд үргэлжлүүлэн цагдан хорих үндэслэл байна уу гэдгийг бол бас авч үзнэ. Тэгэхээр ингэснээрээ бол тэр баривчлах ажиллагаа бол ер нь прокурорын болон шүүхийн хяналтад бол бүрэн орж ирж байгаа гэж ойлгож болно. Тэгэхээр прокурор өөрийнхөө эрх хэмжээний хүрээнд нийт баривчилгааны 40 орчим хувь бол ингээд суллаж байна л даа, суллагд явуулж

байна. Гэтэл тэр сулласан хүмүүсийн асуудал бол шүүхийн хяналтад өнөөдөр байхгүй байгаа юм. Тийм учраас би үндэслэлгүй баривчлагдсан гэж үзвэл тэр хүн гомдлоо шүүхэд гаргах эрхтэй. Прокурор холбогдох материалыг шүүхэд хүргүүлж, шүүх хууль бусаар баривчилсан эсэх дээр бол хэлэлцэж дүгнэлт гаргана. Үлдсэн гомдол гаргаагүй ч гэсэн тэр бүх материалыг бас 30 хоногийн дотор шүүхэд хүргүүлж, шүүх энэ дээр хууль хуулийн дагуу ажиллагаа явагдсан эсэхийг бол хянана. Ийм байдлаар энэ баривчлах ажиллагааны бол хяналт бол хэрэгжинэ.

Тэгээд шалгуурын тэр 6 шалгуур байгаа гэж ирсэн. Энэний тэр 3 шалгуур нь бол дангаараа баривчлах үндэслэл болохгүй. Тэр нь бол заавал бусад нөгөө 3 нөхцөлийн аль нэг нь байж баривчлах үндэслэл болно гэж энэ үндэслэлийг бол илүү нарийвчилж ингэж тусгаж өгсөн. Тийм учраас зайлиггүй хуульд заасан үндэслэл байгаа.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Хариулт хангалттай юу? Нэмж асуух, тодруулъя. Мөнхцэцэг гишүүнд микрофоныг өгье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ Хууль зүйн сайдын түрүүчийн танилцуулга дотор энэ яллагдагчаар цагдан хоригдсон хүмүүсийн тоо дүн статистик бол ер нь жил ирэх тутам буурч байгаа. Өөрөөр хэлбэл шүүхийн зөвшөөрөлгүй баривчлагдсан, цагдан хоригдсон иргэдийн тоо бол буурч байгаа гэсэн дүнтэй байгаад байгаа юм. Тэгэхээр яг одоо энэ үйлчилж байгаа энэ хуулийн хүрээнд ер нь прокурорын зүгээс яг энэ үндэслэлгүй цагдан хоригдсон, шүүхийн зөвшөөрөлгүй баривчлагдсан сэжигтнүүдэд нийт хэдэн хувьд нь хяналт тавиад, шүүх тэр сэжигтнүүдийг сулласан юунууд нь тоо баримт нь хэр байдаг вэ? Ер нь болбол энэ прокурорын зүгээс бол яг энэ хууль маань ингээд шинээр өөрчлөлт ороод явахад болбол харьцангуй хүний эрхийн дэвшилийг бол бий болгоно гэж үзэж байна гэж ойлгож болох уу?

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон. Энэ манай ажлын алба гишүүдийг оруулаарай.

Б.Батицэрэн: Тэгэхээр та ингээд цагдан хорих ажиллагааны талаар асууж байна. Тэгэхээр одоо хэрэгжиж байгаа хуулиар бол энэ цагдан хорих арга хэмжээ авах, түүнийг сунгах энэ ажиллагаа бол шүүхийн хэлэлцүүлгээр заавал дамждаг болсон. Нэг талаас прокурор тэр баривчлах үндэслэлээ танилцуулна. Нөгөө талаас яллагдагч, өмгөөлөгч энэ талаар бас өөрийнхөө саналыг хэлж мэтгэлцэх. Энэ хэлэлцүүлгийн явцад шүүх шийдвэр гаргах ийм журмаар бол хэрэгжиж байгаа. Энэ ажиллагаа бол хэвээр. Гэхдээ цагдан хорих үндэслэл маань илүү объектив болж бас өөрчлөгдөж байгаа. Өөрөөр хэлбэл хүнд гэмт хэрэгт холбогдсон учраас эсвэл хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан ингээд тийм субъектив байдлаар цагдан хорих арга хэмжээ авдаг, сунгадаг ийм үндэслэлүүд бол байхгүй болж байгаа. Тэр нь бол яг тэр хуульд заасан тодорхой ийм, ийм.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Нэмж хариулах уу? 2 дугаар микрофон хариулж дуусаагүй байна нэмж 1 минут өгье.

Б.Батицэрэн: Тийм. Тэгэхээр цагдан хорих арга хэмжээ авах үндэслэл илүү объектив болж байгаа учраас энийг шүүхийн хэлэлцүүлгийн явцад нотлох чиг үүрэг бол прокурорт байна. Тэрийг бас үгүйсгэх няцаах боломж бол яллагдагч, түүний өмгөөлөгч нарт байна. Энэ хэлэлцүүлгийн явцад бол шүүх хуульд заасан шалгуурыг үнэхээр хангасан тохиолдолд бол энэ арга хэмжээг авах, сунгах асуудлыг шийдвэрлэх ийм зохицуулалтууд шинээр орж ирж байгаа юм.

Д.Цогтбаатар: Хариулт хангалттай юу Мөнхцэцэг гишүүнээ? Тэгвэл Раднаасэд гишүүн бишээ, Пүрэвдорж гишүүн. Миний энэ урдах юуг юу дэлгэцийг өгчхөөч, юу нөгөө асуух асуулттай гишүүдийн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр ер нь бол Үндсэн хуулиар заагдсан хүний халдашгүй бүрэн эрхийг хангах тухай асуудал бол мэдээж үе үеийн сайд нар тэр ажлаа сайжруулахын төлөө явдаг. Тэгэхдээ ер нь бол ихэнх нь тэнд очоод удахаараа яг энэ хуулийн байгууллагуудын бас тодорхой магадгүй нэг талаас бас хууль хуулийн байгууллагууд бас тодорхой гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх тийм зайлшгүй шаардлага нэг талаасаа байдаг. Нэг хэсэг хүмүүсийн эрхийг зөрччихсөн, тэрнийгээ бас тодорхой хэмжээгээр илрүүлж, тэр хэргийг нь илрүүлэх нь бол хууль хяналтын байгууллагын бас тодорхой үүрэг. Тэгээд яг энэ өнцгөөсөө бас тодорхой хэмжээгээр яг энэ хууль зүйн салбарын бодлогыг гаргаж байгаа Хууль зүйн сайддаа нөлөөлдөг юм уу яадаг юм бас ингээд чимээгүй болчихдог ийм тохиолдол байдаг. Тэгэхээр энэ дээр бас тодорхой хэмжээгээр маш хурдан энэ иргэдийн эрхийг хангах талаар асуудлаа оруулж ирж байгаа Энхбаяр сайдад бас талархлаа илэрхийлье.

Тэгэхээр энэ дээр бас нэг зүйл байна. Манай нэг найз байдаг юм л, байсан юм л даа. Нэг жоохон гэмт хэрэг хийчихсэн юм. Тэгээд л тэр нөхрийг ингээд л манай тэр мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, өмгөөлөгч энэ 4 нийлж байгаад жонглёрдсоор байгаад л тэгээд л ерөөсөө хэдэн жил явуулаад, сүүлдээ тэр манай Ховдын хамгийн сүрхий бизнесмен байсан. Сүлдээ ерөөсөө хамгийн ядуу нь болж хувираад, тэгээд сүүлдээ нас барсан юм. Тэгээд ийм тохиолдлууд маш их байгаад байгаа юм. Тэгээд ерөөсөө энэ нөгөө мөрдөн шалгах хугацаа, тэр хорих хугацаа тэр бүх зүйл нь, тэгээд дээрээс нь Дээд шүүхээс буцах, дахиад тэр нөгөө шат шатын шүүхээс буцаадаг, тэгээд л буцаагаад л болох гэж байна, болохгүй байна энэ тэр гэж явуулсаар байгаад тэгээд л хамаг хөрөнгөөр нь тоглоод дууссан ийм тохиолдол бас байгаад байгаа л даа. Тэгэхээр ийм зүйл дээр бас тодорхой яг энэ хорих хязгаарлах тэр хугацаанууд нь жил жилээр нь тодорхой хугацаатай, тэгээд тэрэн дотроо

шийдэгдэхгүй болбол цаашидаа ямар арга хэмжээ авах вэ?

Өөрөөр хэлбэл 18 дээд одоо тал нь 5 жилтэй хэрэг дээр 12 сар байна тийм үү, 12 сар байна хорих хугацаа нь. Тэгээд тэр хүн айс гараад хорих хугацаа нь дуусчихлаа. Тэр тохиолдолд гадуур мөрдөн байцаах үйл ажиллагаагаа явуулаад явуулах тэр хугацаа нь бас дахиад хэр зэрэг юм бэ? Тэр нь бас дахиад тодорхойгүй үлдэж байгаа юм биш биз дээ? Яг энэ бусад нөгөө хуулиудаараа нөгөө юу нь зохицуулагдаж байгаа юу? Яг тэр мөрдөн шалгах хугацаанууд чинь, дахиад л нөгөө ямар ч утгагүй, хэдэн жил болдог тэгээд л нэг тийм ялангуяа эрх баригч нар хуулийн салбараа атгадаг, тэд нар тэгээд ингээд нэг тийм байнгын төмсөгтэй байлгаж байх ийм сонирхолтой байгаад байна л даа. Тэгээд хэдэн жилээр болдог юм бэ? Энэ зүйлүүд чинь яаж энэ хууль дээр уялдаж зохицуулагдаж байгаа юм бэ? Энэ дээр бас тодорхой хариулт өгнө үү гэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон.

Б.Батцэрэн: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр мөрдөн шалгах хугацаа гэж ойлголт бий. Процесс хуулийн 31.13 дугаар зүйлд зааснаар зохицуулагдсан. Прокурор шат шатын прокурорууд тэр хуульд заасан эрх хэмжээний хүрээнд тэр мөрдөн шалгах хугацааг зохицуулалт сунгах асуудлыг шийдвэрлэдэг. Гэхдээ тодорхой ажиллагаа хийхгүйгээр ингээд сунгаад, хүний эрх зөрчигдөөд байвал яах вэ гэдэг. Тэгэхээр энэ процессын хуулийн 1.13 дугаар зүйлд мөрдөн шалгах ажиллагааны явцад хүний эрх зөрчигдвөл энэ талаар тэр эрх нь зөрчигдөж байгаа хүн шүүхэд гомдол гаргах эрхтэй гэдэг ийм ерөнхий ангийн заалт байгаа юм. Энийг хэрхэн хянах шийдвэрлэх вэ гэдэг харин процессын зохицуулалт нь бол яг энэ асуудлын хувьд бол гүйцэд зохицуулагдаагүй байгаа. Сая 2020 онд эрүүгийн процесс Эрүүгийн хуулийн

нэмэлт, өөрчлөлтөөр энэ мөрдөн шалгах хугацаа бол бас нэг хэмжээ хязгаартай байх ёстой. Энэ нь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг 2 дахин нэмэгдүүлснээс илүү гарах хэмжээнд байж болохгүй гэдэг ийм нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Өөрөөр хэлбэл хөнгөн гэмт хэргийн хувьд хөөн хэлэлцэх хугацаа нэг жил гэж үзвэл мөрдөн шалгах хугацаа бол хэзээ ч 2 жилээс илүү хугацаанд явагдаж болохгүй. Энэ хугацаа дуусвал энэ хэрэг хэрэгсэхгүй болгогдох ёстой эсвэл энэ нотлогдсон хэргийн хүрээнд гэм буруугийн асуудлыг шүүх рүү шилжүүлж шийдвэрлүүлэх ёстой.

Бусад улс оронд ингээд сайн туршлагыг нь судлаад үзэхэд бол мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавьдаг, мөрдөн шалгах ажиллагаанд гарсан гомдлыг шийдвэрлэдэг ийм шүүхийн тогтолцоо бол байна. Тэгэхээр Шүүх байгуулах тухай хуулийн хүрээнд Хялбар хэргийн шүүх байгуулах тухай ийм төсөл орж ирж байгаа. Тэнд хялбар хэргийн шүүх бол энэ зөвшөөрөл олгох асуудлыг дагнан шийдвэрлэх, магадгүй энд зөвхөн цагдан хорих баривчлах биш бусад Үндсэн хуульд заасан хүний суурь эрхийг хөндөж хийгдэх ажиллагааг бас шүүхэд ингээд шилжүүлэх, тэгээд мөрдөн шалгах ажиллагааны явцад гарч байгаа хүний эрхийн зөрчлийн асуудлуудыг хянан шийдвэрлэдэг ийм байдлаар энэ мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавьдаг шүүхийн тогтолцоогоо тусад нь ингээд зохицуулах юм бол энэ асуудлыг бол шийдвэрлэх нэг арга зам гэж ингэж харж байгаа юм. Тийм.

Д.Цогтбаатар: Нэмэлт асуух уу? Сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Пүрэвдорж гишүүн бас чухал асуудал хөндөж байгаа юм. Өөрөөр хэлбэл төрийн албан хаагч хууль зөрчиж энэнээс иргэдэд хохирол учруулж байгаа асуудал шүүхээр нотлогдсон, тухайн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас ер нь хохирсон хэчнээн иргэн байдаг вэ гэж. Нийт 425 иргэн байна. Шүүхийн шийдвэр гарчихсан.

Өөрөөр хэлбэл энэ иргэдийн хохирлыг мөнгөөр үнэлээд төрөөс гаргах шүүхийн шийдвэрүүд гарчихсан, хурчихсан бас ийм асуудлууд байгаа. Энийг бас үе шаттай бага багаар тусаад тусаад шийдвэрлэж явдаг. Энэ оны 9 сарын байдлаар Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг зөрчиж, саяын хэлсэн хүнийг үндэслэлгүйгээр цагдан хорьсон, хэлмэгдүүлсэн асуудлаар шүүхийн шийдвэр гарч хохирогчийн зөрчсөн хэсгийг сэргээх чиглэлд 2,4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа юм байна. Энэ нь ерөөсөө төсөвт тусгаж тусгахгүй ингээд орхиод байдаг. Сангийн яам зүгээр ингээд хасчихдаг.

Миний хувьд энэ хуулийн үзэл санаатай хамт ер нь 100 хувь яг энэ хүмүүсийн хохирлыг 2,4 тэрбум төгрөгийг 24 онд багтааж би барагдуулна гэсэн бодолтой байгаа. Төр өөрөө хүний эрхийг зөрчихөөд, өөрийн төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас хүнийг хэлмэгдүүлчээд, өөрөө шүүхийн шийдвэрээ биелүүлдэггүй байж таарахгүй. Тийм учраас төр хэрвээ хүний эрх ярих гэж байгаа бол өөр дээр нь холбогдуулж тэр гарсан тэр шийдвэрийг биелүүлэхээс өөрөө манлайллаа эхлэх ёстой гэж үзэж байгаа юм. Төр өөрийнхөө эрхийг, өөрөө зөрчсөн иргэнийхээ эрхийг өөрөө сэргээх ажлаа хамгийн түрүүнд үлгэрлэдэг байх ёстой гэж үзэж байгаа. Тийм учраас би бол хэдийгээр нэр зааж батлагдаагүй ч гэсэн салбарын сайдын хувьд, төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд энэ асуудлыг ямар нэгэн байдлаар багтааж энэ эрх нь зөрчигдсөн шүүхээр эрхийг нь сэргээлгэх шийдвэр нь гарсан энэ хүмүүсийн хохирлыг 100 хувь барагдуулна гэсэн бодолтой байгаа гэдгийг бас хэлье.

Д.Цогтбаатар: Тодруулъя. Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Энхбаяр гишүүн, Сандаг-Очир гишүүн бид 3 санаачлаад Дээд шүүхээс хэрэг буцдаггүй байх энэ заалтыг оруулсан Эрүүгийн хуульд оруулсан байгаа. Тэгээд энэ хуулийг

хэрэгжих явцад хэдэн хэрэг Дээд шүүхээс буцав, тэрний тоог өгнө үү?

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон.

Б.Батцэрэн: 2022 оны 6 сарын 3-ны өдрийн ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар давж заалдах хяналтын шатны шүүхээс хэргийг прокурорт буцаах тэр 39.9, 48.1.3-д заалтуудыг тус тус хүчингүй болгосон. Тэгэхээр энэ үзэл санаа бол хэрвээ хэргийг нотолж чадаагүй бол хэрэгсэхгүй болгох, нотолж чадсан бол тэр хууль зүйн хариуцлагыг хүлээх ийм үзэл баримтлалаар энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт оржээ гэж харж байгаа. Гэхдээ энэ нэмэлт, өөрчлөлт нь бол хуулийнхаа бусад зүйл хэсгүүдтэй бас харилцан уялдах ёстой. Шүүхээс буцаасан хэргүүд дотор яг прокурорт буцаасугай гэдэг ч юм уу эсвэл анхан шатын шүүхээр дахин хэлэлцүүлсүгэй гэдэг яг ийм томьёоллоор шийдвэрлэсэн хэргүүд бол байхгүй. Харин тэр.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофоныг нэмээд өгье, гүйцээгээд хариулъя.

Б.Батцэрэн: Анхан болон давж заалдах шатын шүүхийн шийдвэр хуульд нийцээгүй, хуулийг буруу хэрэглэсэн, ЭХХШТХ-ийг ноцтой зөрчсөн, шүүхийн тогтоосон хэргийн үйл баримт нь хэргийн жинхэнэ бодит байдалтай нийцээгүй ийм 3 тохиолдолд энэ шүүхийн шийдвэрүүд бол хүчингүй болох ёстой гэдэг ийм үүрэг болгосон хэм хэмжээг энэ ЭХХШТХ-ийн 39, 5 дугаар зүйл дээр хуульчлан заасан. Энэ өнөөдөр хүчин төгөлдөр байгаа. Энэ хүрээнд давах хяналтын шатын шүүх анхан, давах шатын шүүхийн шийдвэрийг хянаад, тэр хууль зөрчсөн шийдвэрийг бол хүчингүй болгож шийдвэрлэж байгаа. Хүчингүй болгосон шийдвэрийн хууль зүйн үр дагавар яаж байна вэ гэхээр прокурор энэ хэргийг санаачилж тэр гарсан алдаа зөрчлийг засах, зөвтгөх нэмэлт ажиллагаа хийх, хаана алдаа гарсан тэр

шатнаас нь энэ зөвтгөн шийдвэрлэх ажиллагаа бол хийгдэж байгаа.

Д.Цогтбаатар: Адьшаа гишүүн.

Ш.Адьяа: Манай Энхбаяр сайд болоод хэд хэдэн хуулийн төсөл өргөн бариад бид хэлэлцээд байгаа. Одоо бас энд болбол нийгэмд бас эргэлзээ төрүүлсэн, шүүмжлэл дагуулсан ялангуяа энэ ялын бодлогын асуудал түүнчлэн гэмт хэргийн бүрэлдэхүүний асуудлаар бол бас нэлээн ярилцаж, хэлэлцэх ийм асуудлууд тулгарсан байгаа. Энийг хэлэлцүүлгийн шатанд болбол хууль тогтоогчид мэдээж олон талаасаа ярилцаж шийдэл гаргана. Харин өнөөдрийн энэ оруулж ирж байгаа энэ хууль болбол тэр хүний үндсэн эрхийг шүүх эрх мэдэл, прокурор, мөрдөх байгууллагын харилцан уялдааны асуудал, хэрэг илрүүлэхэд хэрэглэж байсан хүний эрхийг зөрчдөг ийм аливаа энэ буруу зүйлээс салах оролдлого хийсэн, энэ хонгилын гээд яриад байдаг энэ хуйвалдаан түүнчлэн өнөөдөр хүний эрхийн талаар бас мэдрэмжтэй ийм шийдэл гаргасан ийм хууль байна гэж үзэж, үзэл баримтлалын хувьд энд хэлэлцэхийг хууль тогтоогчийн хувьд болбол дэмжиж байна.

Энд болбол нэг 2, 3 тодруулах зайлшгүй шаардлагатай асуудал байна. Тэр цагдан хорих байранд мөрдөн шалгах ажиллагаа явуулахтай холбоотой өөрчлөлт болбол бас яригдах л асуудал. Тэгэхдээ энд том, жижиг хэрэг гэж байхгүй. Цагдан хоригдож байгаа этгээдүүдтэй холбогдуулж бас энэ гүйцэтгэх ажил гэдэг бол тэр хэрэг биш түүнтэй өөр хэрэг илрүүлэхэд болбол бас их ач холбогдол өгдөг ийм судалгаа мэдээлэл байдаг. Тэгэхээр энэ дээр бас хэлэлцүүлгийн явцад бас ярих асуудал гарч ирэх байх гэж бодож байна. Энэ ер нь хэр оновчтой шийдэл вэ гэж. Ялангуяа энэ малын хулгайн асуудал, олон аймаг дамжсан маш их хэмжээний зохион байгуулалттай энэ гэмт хэрэг чинь ингээд л гүйцэтгэх ажил явуулахгүйгээр шийдэх ямар гарц байна гэдгийг нэг хариулт авъя.

Өнөөдөр ингээд мөрдөх байгууллага, прокурор, шүүх болбол энэ мэтгэлцээний зарчим, хүний эрхийг хангах энэ дээр болбол шинэ шийдэл гаргаж байгаа нь бас сайн хэрэг байна. Гэхдээ энд нэг бас зайлигүй тодруулах шаардлагатай асуудал байна гэж миний бие ойлгож байна. Яагаад гэхээр өнөөдөр ингээд мөрдөх байгууллага гэмт хэрэг илрүүлэхдээ өдөр, шөнөгүй, амралтын цаггүйгээр ингэж ажилладаг. Гэтэл өнөөдөр амралтын өдрүүдэд энэ гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хойшлуулиггүйгээр баривчлах саатуулах ийм асуудал гарвал шүүх прокурорынхоо асуудлыг яаж шийдэх вэ? Энэ дээр бол гэрээс нь очиж авах юм уу аль эсхүл тэр амралтын өдрүүдэд ажиллах, шүүх, прокурорын асуудлуудыг бүтэц орон тооны хувьд, зохион байгуулалтын хувьд шийдэх юм уу гэдэг энэ асуудлыг бас тодорхой болгож өгөх шаардлагатай байна гэж ойлгож байгаа. Нөгөө талаасаа энэ хууль хэрэгжиж үр дүнгээ өгвөл Монгол Улсын энэ ЗГ-аас хэрэгжүүлж байгаа хүний эрхийг хүндэтгэх олон улсын өмнө хүлээсэн үүрэг түүнчлэн хүний энэ онцгой эрхтэй холбоотой энэ асуудал шийдэгдэх ийм сайн үр дагавар гарна гэж найдаж байна. Тэгээд энэ 2 асуултдаа би хариулт авъя.

Д.Цогтбаатар: Хэн хариулах вэ? Сайд.

Б.Энхбаяр: Адъяаа гишүүний энэ бас тэр шүүхтэй холбоотой асуудлыг Батцэрэн шүүгч хариулах байх гэж бодож байна. Хүний халдашгүй чөлөөтэй байх эрх гэдэг бол хэн нэгний тэр дотроо төрөөс юм уу энэ бэлэглэдэг эрх бол биш. Энэ бол заяамал эрх, хүний салиггүй эрх. Гагцхүү хуульд заасан үндэслэл журмаар л энэ эрхэд халдах ёстой. Энэ эрхэд халдах боломж олгож байгаа хуульд хэн нэгэн дур зоргоор тайлбарлах үндэслэл бичиж бид болохгүй. Ингээд л бичих юм бол хэн нэгнийг энэ дахин гэмт хэрэг үйлдэх гээд байсан юм, мэдэхгүй хэзээ үйлдэх гээд байсан юм, зүгээр тийм хар бараан царайтай сэжигтэй харагдаад байсан юм

уу бүү мэд. Ийм барих барьцгүй үндэслэлээр энийг хуульд бичвэл энэ нь өөрөө нөгөө хууль сахиулж байгаа хүмүүсийн тухайтад нөгөө хонгил үүсдэг, хэлмэгдүүлэлт үүсдэг, тэр боломжийг олгодог юм байна. Тийм учраас хуулийн хийдэл байгаа бол энийг хуулиар нь л өөрөө хаах ёстой. Бид хэлмэгдүүлээд байна, хонгил үүсээд байна гээд зүгээр ярихаас илүү тийм боломж олгоод байгаа нүх сүвнүүдийг бүгдийг нь бөглөх ёстой байхгүй юу. Тэгж байж бид Үндсэн хуульд заасан энэ халдашгүй чөлөөтэй байх эрхээ манана. Яг энэ агуулгаар энэ үзэл баримтлалыг оруулж ирсэн.

Оруулж ирэхдээ нэг их НҮБ дүгнэчихээр нь цочиж, гадаад талдаа нэг сайхан муухай харагдах гэж оруулж ирээгүй. Хэн нэгэнд таалагдах агуулга энд ерөөсөө байхгүй. Хүний үндсэн жам ёсны эрхийг хамгаалах гэдэг дээр бид өөрсдөө хатуу байх ёстой, хатуу. Төр буюу дур зорго ямарваа нэгэн байдлаар орж ирэхээс ямагт урьдчилан сэргийлдэг байх ёстой. Яагаад гэхээр тэр мангас бол ийм чөлөөтэй орчинд маш амархан амилах бололцоотой байгаа. Тийм учраас би өөрөө ХЗДХ-ийн сайдын хувьд бол би хүний эрхийн сайд байна гэсэн лоозон өөртөө дотор, дотор хүнтэйгээ яриад хатуу тангараглачихсан байгаа. Энийгээ өөрөө манлайлж ажиллахын төлөө байгаа. Яг энэ агуулгаараа хамгийн бас анхны санаачилж байгаа хууль маань хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн асуудлыг. Тэгэхдээ энэ зөвхөн нэг хэсэг. Олон асуудлууд байгаа. Нэг амьсгаагаар хийх юм бол бас асуудал үүсэх юм байна лээ. Манайхан чинь бол өмнө нь бол бас их хүнд, хүнд туршилагатай. Би ч гэсэн бас дэд сайдаар ажиллаж байх үед янз янзын санал санаачилга гаргаж л явсан. Янз янзын асуудал юмнууд үүсэж л байсан асуудал байдаг юм. Тийм учраас би энэ асуудлыг үе шаттай шийднэ, үе шаттайгаар оруулж ирнэ. Тийм.

Тэр цагдан хорих байранд гүйцэтгэх ажлын хийхийн тухайд бол энэ бол сүүлийн 10 жил 3 дахь удаагаа Их Хуралд орж байгаа шүү, 10 жилийн

хугацаанд. 2010 онд, 13 онд Тэмүүжин Хууль зүйн сайд байхдаа цагдан хорих байранд гүйцэтгэх ажил хийхийг хязгаарлах чиглэлээр хуулийн төслөө өргөн барьж байгаад татагдаад, Дорлигжавыг батлагдахад энэ өргөтгөж батлагдаад, дахиад миний тухайд дэд сайд байхад дахиж хязгаарлаж оруулаад, тэгсэн чинь нөгөө гүйцэтгэх ажлын байгууллагууд Их Хурал дээр лобби хийж байгаад энийг өргөтгөөд малын хулгайг нэмчихсэн юм. Яадаг гэхээр таалагдахгүй хүнээ нэг малын хулгайчтай нэг камерт хийчихдэг байхгүй юу. Тэгээд малын хулгайчийг чагнаж байгаа гэдэг нэрээр.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Тодруулга. Түүрүүн Батцэрэн шүүгч бас нэг хариулчихъя. Тэгээд та тодруулах уу Адьшаа гишүүнээ?

Б.Батцэрэн: Тэгэхээр баривчлах ажиллагаа бол хуулиар зөвшөөрсөн журмын дагуу явагддаг тийм ээ. Өөрөөр хэлбэл үнэхээр хойшлуулигүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тэр гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа хүнийг оргон зайлах, гэмт хэргээ төгсгөх, гэмт хэргийн ул мөр, нотлох баримтаа устгах, мөн хамтран гэмт хэрэг үйлдсэн хүн эсвэл энэ хэргийн гэрч, хохирогчид хууль бусаар нөлөөлөх энэ эрсдэлээс сэргийлэхийн тулд бол зөвшөөрөл шүүхийн зөвшөөрөлгүй бол баривчилж болдог. Гэхдээ энд тэр хүний эрхийн зөрчил байна уу гэдэг дээр шүүхийн хяналт бол тасралтгүй хэрэгжиж байх ёстой. Энэ үүднээс хуульд шүүх хуанлийн өдөр бүр өдрийн цагаар буюу шөнийн бус цагаар тасралтгүй энэ хяналтыг хэрэгжүүлнэ гэсэн ийм агуулгатай заалт орж ирж байгаа юм. Энэ бол амралтын өдөр, баярын өдөр хамаарахгүйгээр өдөр бүр ийм жижүүрийн шүүгч ажиллана. Энэ шүүгчийг бол шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон хуваарийн дагуу тусгайлан томилж ажиллуулна.

Тэгэхээр энэ журам бол бас процесс хуулийнхаа нийтлэг журамд нийцсэн байх ёстой. Тэр өдрийн цаг гэдэг бол өглөөний 6 цагаас шөнийн 22 цаг

хүртэл хугацааг хэлж байгаа юм. Тэгэхээр энэ хуулиар бол энэ баривчлах ажиллагаа явагдсан хэргийг шүүхэд шилжүүлбэл шүүх 24 цагийн дотор шийдэх ёстой. Тэгэхээр даруй шийдэж болно. Үнэхээр 22 цаг хүрсэн байвал маргааш өглөөний 9 цаг хүртэл хойшлуулаад, тэр 24 цагтаа багтааж, ингэхдээ тэр хүний эрхийг хангаж, өмгөөлүүлэх эрхээр нь хангаж ингэж шийдвэрээ гаргана. Тэгэхээр энэ өмгөөлүүлэх эрхийн хүрээнд бол бас тусгайлан заалт орж ирж байгаа. Энэ дээр өмгөөлөгчийг томилж ажиллуулах журмыг Өмгөөлөгчдийн холбооны саналыг үндэслэн Хууль зүйн сайд, хууль зүйн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн батлахаар орж ирж байгаа. Дээр нь энэ ээлжийн шүүгчийн ажиллах журмыг Улсын дээд шүүх бас баталж, хэрэгжүүлэхээр хуульд тусгагдаж байгаа. Тэгэхээр энэ хуулийн хүрээнд батлагдсан энэ журмын дагуу энэ баривчлах ажиллагааны хяналт бол ингээд бодитой тасралтгүй хэрэгжих боломжтой болно гэж.

Д.Цогтбаатар: Тодруулах уу? Би тэгвэл 2 асуулт асууна. Энэ Энхбаяр сайдаас асуумаар байна. Ингэж байна л даа яг дараах гэмт хэрэгт цагдан хорих байранд мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахыг зөвшөөрнө гээд, зөвшөөрч байгаа яг тодорхой тэрийг чинь ингээд заалтууд гаргаад ирж байгаа юм. Дараахыг хориглоно гээд. Би энэ дээр нэг санаа зовж байгаа юм нь Энхбаяр сайдаа ингээд тодотгоод заачихаар эрх зүйн позитивист хандлагаасаа аваад үзвэл энэ дээр чинь яг тэр саарал grey area буюу энэ дунд алинд нь ч хамрахгүй юу үлдчих эрсдэл байгаа шүү дээ. Энийгээ яаж шийдэж байгаа юм бол нэг асуулт. Тэгэхлээр энд бичигдээгүйгээс өөр бусад юм нь яаж зохицуулагдаад үлдэх вэ? Тийм эрсдэл байгаа юу нэг?

2-т энэ нөгөө ингэж байна л даа. Энэ хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг гээд энэ юүскоженс-г хэлээд байна л даа. Монголоороо ингээд нэршээд тогтчихсон

билүү энэ чинь? Яагаад гэхээр юүскоженс гэдэг бол өөрөө аягүй өргөн хүрээний ойлголт. Энэ дээр хүн төрөлхтний аюулгүй байдал энх тайвны эсрэг гэмт хэрэг гэдэг бол энэ юүскоженс гэдэг энэ том ойлголтын зөвхөн нэг хэсгийг нь л тусгачихсан байгаад байна. Энэ чинь ингээд тогтчихсон томьёо байгаа билүү, эсхүл зүгээр танилцуулга дээрээ ингээд нэршээд ороод ирж байна уу? Ийм 2 асуулт асуух гэсэн юм.

Б.Энхбаяр: Би нөгөө хуулийн бичилтийг нь эрхэм гишүүд эрхэм гишүүдээрээ уламжлуулаад бас үзэж сонсож байгаа иргэдэд илүү хүний хэлээр нөгөө ойлгомжтой болгохын тухайтад ингэж ангилаад бичсэнээс улбаалаад ийм ойлголт гарчхаж байгаа юм. Одоо ЭХХШТХ-ийнх нь бичилт нь энэ, энэ хэргүүдээс бусад хэрэгт цагдан хорих байранд гүйцэтгэх ажил явуулахыг хориглоно гэсэн бичилттэй байгаа юм. Хуулийнх нь зүйл анги нь энэ. Тэрэн дотроос нь хулгайлах, мал хулгайлах, хар тамхины 4 энгийн хэрэг, тэгээд бусад бүх гэмт хэргүүд гүйцэтгэх ажил явуулахыг хориглоххож байна гэсэн үг. Хуулийн текстийн хувьд бичилттэй үлдэж байгаа нь болохоор саяын дурдсан 5 хэрэг. Хүн алах, хүчиндэх, үндэсний аюулгүй байдал, авлига, хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг. Тэгээд зохион байгуулалттай хар тамхи. Энэ хэдийг үлдээчихээр ерөөсөө энэнээс бусад бүх хэргүүд дээр цагдан хорих байранд гүйцэтгэх ажил хийхийг хориглоно гээд одоо хуулийн текст нь тийм болж байгаа юм. Тэгэнгүүт нөгөө тэгж ялгаж харахад ойлгомжтой байдлаар одоо байгаа хуулиас нь аль аль хэргүүд дээр нөгөө гүйцэтгэх ажил хийдгийг нь хасаж байгаа вэ гэдэг нь тэр хориглоно гэдгийг нь биччихсэн юм. Одоо бол энэ төрлийн хэргүүд дээр гүйцэтгэх ажлыг хийж байгаа гэсэн үг одоо хуулиараа. Тэгэнгүүт энийг хасаад энийг үлдээлээ гэнгүүт зөвхөн энэ саяын ярьсан 5 төрлийн хэрэг үлдчихэж байгаа юм. Таны 2 дахь асуултын тухайд хэн хариулах вэ? Би ч бас л эрүүгийн эрх зүйн дагнасан мэргэжилтэн эксперт бол биш шүү дээ

судлаач. Эрдэм-Ундрах доктор хариулах уу? Яг эрүүгийн эрх зүйгээр дэлхийн загвар Эрүүгийн хуулиар Германд доктор хийсэн хүн шүү дээ.

Л.Цогтбаатар: 1 дүгээр микрофон өгье.

Х.Эрдэм-Ундрэм: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг гэдэг энэ гэмт хэргийг 2015 оны Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэгт тусгайлсан бүлэг болгож оруулсан байгаа. Өмнө нь болбол өөр зохицуулалттай байсан. Энд болбол нөгөө дайны эсрэг гэмт хэрэг, геноцит болон бусад гэмт хэргүүд бол багтдаг. Тэгээд манай Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын энэ шинэ бүтцэд бүтцээр ингэж томьёолж оруулсан юм байгаа юм.

Д.Цогтбаатар: Өөрөөр хэлбэл хэвшчихсэн томьёолол байна шүү дээ.

Х.Эрдэм-Ундрах: Тийм хэвшчихсэн.

Д.Цогтбаатар: Яагаад гэхээр энэ дээр зүгээр миний болгоомжилж байгаа юм өөрөө тэгвэл тэр баруунд юу хамгаалсан бол энэ чинь р., norms гэж байгаа шүү дээ. Өөрөөр хэлбэл юүскоженс гэдэг чинь Монгол энэ томьёоноосоо бол хамаагүй өргөн утгатай. Энэ чинь яг аюулгүй байдал гээд тодотгочхож байгаа байхгүй юу, нарийсгачхаж байгаа юм. Тэгээд энх тайвны эсрэг гэмт хэрэг гээд. Тэгэхээр уг ойлголт нь бол юүскоженс юм бэ шүү дээ?

Х.Эрдэм-Ундрах: Тийм.

Д.Цогтбаатар: Тэрийгээ бид нар ингэж ойлгоод байгаа юм байна тийм үү?

Х.Эрдэм-Ундрах: Монголоор ингэж томьёолж.

Д.Цогтбаатар: Ойлголоо. Юун дээр бол Энхбаяр дарга тэр зөвшөөрч

байгаагаа яг тодотгож зааж өгөөд л, тэрнээс бусад нь бүгд хоригдчихож байгаа юм байна шүү дээ тийм ээ? Окэй ойлголоо. Ингээд асуулт асууж, хариулт авч дууслаа. Энэ хэлэлцээж байгаа асуудлаар санал хэлэх гишүүд байвал нэрээ өгье. Байхгүй байна. Ингээд тэгвэл энэ асуудлаар санал тийм, хэлэлцэх эсэхийг нь дэмжье гэсэн томъёоллоор санал хураая. Байж байгаарай энэ чинь, байж байгаарай санал. Дараагийн юу, 60 хувийн саналаар хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье гэсэн томъёоллоор дэмжсэн байна.

19.38 цаг

Дөрөв.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа орёе. Иргэний, 4 дэх асуудал. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулъя. Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын ЗГ-ын гишүүн, ХЗДХ-ийн сайд Баттөмөрийн Энхбаяр танилцуулна. Энхбаяр гишүүнээ түр хүлээж байгаарай одоохон. Тэгвэл ингээд нэгдсэн хуралдаанд Пүрэвдорж гишүүнийг танилцуулахаар санал, дүгнэлтийг танилцуулахаар томилж байна. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Байнгын хорооны эрхэм дарга, гишүүд ээ,

ШЕЗ-ийн гаргасан 2022 оны мэдээнд Дүүргийн Иргэний хэргийн анхан шатын шүүхийн хэмжээнд хэргийг хэлэлцэх нийт 39691 шүүх хуралдаан зарласнаас 54,4 хувь нь хойшлогдсон байна. Хэрэг хянан шийдвэрлэж байгаа дундаж хугацаа 30-аас 120 хоног, зарим хэрэг 1-ээс 3 жилийн хугацаанд хянан шийдвэрлэгдэж байна. Хэрэг хянан

шийдвэрлэх ажиллагааны удаашралтай байдалд хэргийн оролцогчийн хаяг тодорхой бус, шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг буюу нэг шүүгч, туслахад ноогдох хэргийн тоо их, үүнээс шалтгаалан нэг хэрэг хянан шийдвэрлэх зардлаар 3 хэргийг шийдвэрлэдэг зэрэг хүчин зүйлс нөлөөлж байгаа ч нөгөө талаас бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэхэд тохирсон хянан шийдвэрлэх ажиллагаа хэргийн удирдлагын эрх зүйн орчин бий болоогүйгээс үүдэлтэй байна.

Түүнчлэн нийслэлийн 6 дүүргийн иргэний хэргийн анхан шатын шүүхийн 2022 онд хянан шийдвэрлэгдсэн нийт 34083 хэрэг маргааны 8200 хэрэг буюу 24,06 хувь нь 11 сая төгрөгөөс бага үнийн дүнтэй хэргүүд байна. Эдгээр хэргийг шийдвэрлэсэн дундаж хугацаа 109 хоног бөгөөд нийт шийдвэрлэсэн бага үнийн дүнтэй хэргийн 3,6 хувь нь давж заалдах журмаар гомдол гаргасан бол 1,2 хувь нь хяналтын шатны шүүхэд ханджээ. Иймд хүний зөрчигдсөн эрхийг хялбар, хурдан шуурхай, үр дүнтэй байдлаар шийдвэрлэх бага үнийн дүнтэй хэргийг хянан шийдвэрлэх тусгайлсан журмын эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх зорилгоор Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна.

Уг нэмэлт оруулах хуулийн төслийг дараах агуулгаар боловсруулсан. Бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн шаардлагад тохирсон хэрэг хянан шийдвэрлэх үр дүнтэй, хялбар тусгайлсан журмыг тогтоох бөгөөд энэ нь зөвхөн мөнгөн дүнд хязгаарлагдсан мөнгөн хөрөнгө гаргуулах нэхэмжлэлийн шаардлагад үйлчлэхээр тусгасан. Мөнгөн хөрөнгийн дүнг 1 сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээгээр тогтоож, 6 төрлийн нэхэмжлэлийн шаардлагыг тодорхойлсон. Хэрэг хянан шийдвэрлэх тусгайлсан журмыг тодорхойлж, нэхэмжлэл, шүүхийн мэдэгдэх хуудас гардуулах хурдан

шуурхай, цахим технологийн дэвшилийг ашиглаж болох зохицуулалтыг мөн тусгасан. Бага үнийн дүнтэй хэргийг нэг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх зарчмыг тодорхойлж, цаасан болон цахим нотлох баримтыг шүүхээс үнэлэх зохицуулалтыг тусгасан болно. Хуулийн төсөл батлагдсанаар хэргийн онцлогт тохирсон маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны уян хатан зохицуулалт бий болж, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удааширал багасаж, иргэдэд хурдан шуурхай, хялбар байдлаар үр дүнтэй үйлчлэх шүүхийн хүртээмж дээшлэх болно.

Эрхэм гишүүд ээ, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Ингээд асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Улсын дээд шүүхийн шүүгч Нямдоогийн Баярмаа, ШЕЗ-ийн гишүүн Батсүрэнгийн Ундрах, ШЕЗ-ийн гишүүн Навагчамбын Баасанжав, ХЗДХ-ийн сайдын зөвлөх Дэмбэрэлцэрэнгийн Мөнх-Эрдэнэ, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Нармандахын Жамъянхүү, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн шинжээч Мөнхдэлгэрийн Цолмон, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш Ганхуягийн Давааням, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш Нямсүрэнгийн Норовсамбуу, ХЗБХ хариуцсан референт Хулан оролцож байна.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү? Гишүүнээр тасаллаа.

Н.Учрал: Энэ ЗГ-аас өргөн мэдүүлсэн хуулийг дэмжиж байгаа. Тэгээд Иргэний хэрэг шүүхэд хянан

шийдвэрлэх хууль дээр анх өөрчлөлт оруулах тэр хуулийн төслийн тэр үзэл баримтлалтай нь болбол бас өмнө нь Энхбаяр сайдыг ирэхээс өмнө бол танилцаж байсан. Яг одоо болбол Улсын Их Хуралд нөгөө төрийн үйлчилгээг цахимаар явуулахтай холбоотой хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах 120 хуулийн өөрчлөлтийг өргөн мэдүүлээд хэлэлцэх эсэхийг нь дэмжээд байна. Тэгээд анхны хэлэлцүүлэгт бэлтгэх үеэр ХЗБХ бол санал, дүгнэлтээ өгөх ийм Их Хурлын даргаас чиглэл өгсөн. Тэгэхээр Энхбаяр сайд бол тухайн үед Байнгын хорооны дарга байсан. Ингээд ШЕЗ-ийн саналыг үндэслээд бид энэ 120 хуулийн өөрчлөлтийг оруулахдаа нэгэнт Шүүхийн багц хууль, Иргэний процесс, Эрүүгийн процессын хууль Хууль зүйн яам боловсруулж байгаа, ЗГ-аас өргөн мэдүүлэх учраас энэ 120 хуультай давхцуулж энэ иргэний процессын хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэдэг ийм тайлбарыг өгсөн. Шүүхийг болбол би цахимжилтыг онцгой дэмжээд байгаа юм байна гэж сүүлийн олон удаагийн хэлэлцүүлгүүдээс харсан.

Гэхдээ энэ удаагийн оруулж ирж байгаа энэ иргэний процессын хууль дээр яг нөгөө цахим нотлох баримтыг иргэний процессын шатад нотлох баримт гэж яг үнэлэх үү, үнэлэхгүй юу гэдэг асуудал бас нэг тийм ойлгомжгүй л байдалтай л би орж ирж байна гэж анх бас ЗГ-таа танилцуулах гэж байхад нь ойлгоод байгаа юм. Тэгэхээр яг одоо ялангуяа энэ иргэний хэргийн анхан шатын шүүхийн шийдвэрлэлт дээр болбол маш их ийм ачаалалтай байдаг. Энэ ачааллыг хөнгөлөхөд болбол энэ цахимжуулах болбол асар их чухал. Ялангуяа иргэний процесс дээр. Иргэний хэргийг энэ шүүхэд хянан шийдвэрлэх явцад үүсэж байгаа энэ хэрэг маргаан дээр. Тэгэхээр яг тэр нотлох баримтыг үнэлэх асуудлаа яг энэ хууль дээр оруулж ирсэн юм уу? Тэгээд тэр 100, нөгөө манай яамнаас боловсруулаад тэр өргөн мэдүүлсэн 120 хууль болбол зүгээр нэг цахим, цаасан аль аль нь болно. Аль аль нь эрх зүйн баримт бичиг гэж үзнэ. Архивын хууль дээр

хүртэл цахимд заасан зөрнө гэсэн ойлголт бол байхгүй. Энэ тохиолдолд яг эх хувийг нь бас цахим баримт бичиг гэж тооцож болно ч гэдэг юм уу ингээд агуулгатай нь дүйцүүлээд энэ 120 хуулийг л хийсэн юм шүү дээ.

Анх болбол тэр Нийтийн мэдээллийн хуулийг боловсруулж, нөгөө батлуулах үеэр болбол бичиг баримт, бичиг хэрэг гэдэг бол ард нь цахим цаасан аль алиныг нь ойлгоно гэж бичсэн хэдий ч яг амьдрал дээр ирэхээр энэ байдал бол ялангуяа банк санхүүгийн салбарт, ялангуяа шүүхийн энэ процессын шатад болбол яалт ч байхгүй цагаан дээр хараар бичсэн хуулиуд болбол бас хүндрэл болж байгаа юу гэвэл болж байгаа. Тэгээд энэ амьдрал, онол практик 2 болбол яалт ч үгүй зөрөөд байна л даа. Тэгэхээр та бүхэн өөрсдөө бид нар Шүүхийн багц хууль дээрээ энэ процессынхоо хууль дээр өөрсдөө оруулна гээд тухайн үед энэ 120 хууль дээр оруулах шаардлагагүй гэж үзсэн. Тэгэхээр яг энэ Иргэний процессын хууль дээр энэ цахимжуулахтай холбоотой яг ямар дэвшил өөрчлөлт гарсан юм бэ гэдэг би яг асуултыг асуумаар байгаа юм. Ерөнхий ярих биш, яг ямар өөрчлөлт орж байгаа юм бэ?

Жишээ нь шүүх хуралдааны товьыг хойшлуулахад хүртэл бичгээр гарга гэдэг хуультай шүү дээ. Тэгэхээр нөгөө хотын түгжрэл төвлөрөл гээд л байдаг, яг цаг дээрээ шүүхийнхээ хуралдааны товьыг хойшлуулахын тулд бичгээр хүсэлтээ бариад л шүүх дээр ирээд л өгч байгаа. Тэгээд л нөгөө оочир дугаар үүсгээд л ингээд л явдаг. Зүгээр нэг хойшлуулах хүсэлтийг цахимаар өгчхөж болохыг хуулиар нээгээд л өгчихмөөр л байгаа юм л даа. Тэгээд мянга ингээд цахимжуулалт гээд л яриа л байдаг, танилт нэвтрэлтийн системээс авсан бичиг баримтыг цаасаар шаардахгүй л гээд байдаг, яг шүүх дээр ирэхээр шаардаж л байгаа байхгүй юу. Энэ бол та нарын ч буруу биш, нэгэнт хуульд заачихсан.

Д.Цогтбаатар: Энхбаяр сайд. Энэ сайдын асуултад яг нарийн хариулаарай.

Яагаад гэвэл энэ ёстой бодитой юм асууж байна шүү.

Б.Энхбаяр: Учрал сайд маань энэ цахимжуулалт, тэр дотроо энэ төрийн үйлчилгээ авдаг, шүүхийн үйлчилгээ бол төрийн үйлчилгээний бас нэг хэсэг шударга ёсны үйлчилгээ авч байгаа юм. Шударга ёсны үйлчилгээ. Шударга ёсыг тогтоох гэж байгаа учраас энэ асуудал дээр мэдээж маш ул суурьтай буюу нотлох баримтыг хангалттай хэмжээнд авч үзэж байж шүүх дэнсэлж таарна. Маш олон янзын хэргүүд шийдэгдэж таарна. Тэр дотроо иргэний асуудал бол эд хөрөнгийн маргааны хувьд бол том үнийн дүнтэй хэргүүд шийдэгдэж таарна. Тийм учраас бид цахим залилангаас урьдчилан сэргийлэх технологийн хувьд 1 дүгээрт бэлэн үү гэдэг асуудал байгаа юм. Яагаад гэхээр Иргэний процессын хуулиар шууд үйлчилнэ шууд. Гэтэл бид юу хийгээд яваад байна вэ гэхээр дөнгөж сая энэний өмнөх төсөв дээр 2024 онд шүүхийн цахимжилт дээр анх удаа цахимжилтынх нь асуудлыг нь шийдэх төсвөө сая л яриад сууж байгаа байхгүй юу. Бид бэлэн биш байгаад байгаа байхгүй юу. Бид сая л 10 тэрбум төгрөг шүүхийн системийн хэмжээнд сая мөнгийг нь тавьж өгч байна шүү дээ.

Гэтэл жишээлбэл Герман Улс цахим шүүхийн засаглалд шилжихтэй холбоотойгоор хэд хэдэн мужууд тэр дотор Берлин хотын өөрийнх нь дүүргийн шүүхэд одоо дандаа туршилтын байдалтай байгаа, 5 жил туршиж байна. Шууд шилждэггүй. Жишээлбэл шүүх хуралдааныг цахимаар явуулахтай холбоотой шийдвэрээ 5 жилийн өмнө гаргаад, ирэх оноос хэрэгжинэ, хэрэгжүүлэхээр үзэж байгаа. Ингэж хэрэгжүүлэхдээ байна шүү дээ Герман бол энэ шүүхийн цахимжилтыг хариуцсан IT компанийг шүүхийнхээ дотор байгуулсан байгаа байхгүй юу. Ямар ч хувийн компани оролцуулаагүй. Дэлхийн ямар ч том IT групп, тэр байтугай өөрийн үндэснийхээ IT группүүдийг ч оролцуулаагүй. Зөвхөн манайхаар бол

ШЕЗ-ийнхөө бүтцэд улсын үйлдвэрийн газрын статустайгаар оролцуулж хийсэн байна лээ. Программ нь тийм. Мэдээллийн аюулгүй байдал, тэр гаднын нөлөөлөл орох тэр бүх зүйлээс бүрэн хамгаалагдсан эсэхийг 5 жил туршиж үзэж байна одоо. Тэгж байж хүний хөрөнгийн маргааныг шийдэх тэр шилжилтийг хийх гээд явж байгаа юм.

Тэгэхээр бид бол бэлэн биш байгаа. Би энийг шууд хэлнэ. Шууд жишээлбэл хүний том үнийн дүнтэй маргааныг цахимаар юм уу, зайнаас би шийдчихнэ гэдэгт би бол эргэлзэж байна, бэлэн биш байгаа. Учрал сайд бол бэлэн байж магадгүй. Иргэний шүүгч, шүүгчид бол энэ дээр өөрсдөө тодорхой хариулах байх. ШЕЗ бол нэлээн ажлууд хийгээд танилцуулаад явж байгаа. Энийгээ бас хийх байх. Би яг нотлох баримтыг шууд үнэлэх хэмжээнд бол мэдэхгүй. Тэр байтугай хуулийн этгээдийн бүртгэлээс хүний гэрлэснийг устгачхаад байна шүү дээ, 2 гэрлэсэн хосыг хэзээ ч гэрлэж байгаагүй болгочоод байна. Өөрөө нотариат дээр очоогүй байхад. Миний төрсөн ээжийн байрыг манай ээжийг Улаанбаатар хотод явж байхад хуйвалдаад хүний нэр дээр шилжүүлээд банканд барьцаалсан залилангийн хэрэг гарсан жишээлбэл. Хуулийн этгээдэд байгаа хуулийн этгээдийг мэдээллийн сангаас delete хийчихсэн байна. Асуудал нь шалгагдаад эхлэнгүүт нүүрсний хэргээр. Мэдээллийн сангаас delete-чихсэн, байхгүй огт байгаагүй юм шиг болгочихсон.

Д.Цогтбаатар: Гүйцээж хариулах уу? Эхлээд тэндээс хариултаа гүйцэд сонсчихоод сайдаа тодруулах нь зөв байх.

Н.Баярмаа: Яах вэ одоо яг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон эрх зүйн орчны хүрээнд цахим баримтыг үнэлэх асуудал ямар байгаа вэ гэдгийг хуулийнх нь үг хэллэгээр ийм хуурай байдалтай хариулж болно л доо. Гэхдээ миний хувьд бол би нэг зүйлийг илүү, арай илүү ийм хэлбэл бүүр илүү

практик ач холбогдолтой хариулт байх юм болов уу гэж бодоод байна. Тэр нь юу вэ гэхээр миний би бол саяхныг хүртэлх хугацаанд иргэний хэргийн анхан шатын шүүхэд ажиллаж байсан. Тэгэхээр анхан шатын шүүх дээр нотлох баримт ирэх тэр нь цахим байх, цахимаар туслахуудтай харилцах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахимаар оролцох энэ нөхцөл байдал өөрөө өнөөдөр практик дээр яагаад хүндрэлтэй, яагаад бараг боломжгүй шахам байдаг юм бэ гэдгийг болбол ер нь биеэрээ л мэднэ л дээ. Тэгэхээр хамгийн наад зах нь л зүгээр өнөөдөр та бүхэн маань төсөөлж байгаа байх. Анхан шатын шүүхийн шүүгч 4-өөс 5 программ дээр ажилладаг. Өөрөөр хэлбэл тэнд 2014 гэдэг иргэний системээс гадна, шүүх хуралдааны явцыг илтгэдэг, эрэн сурвалжилдаг өөр маш олон программыг нэг нь зэрэг бөглөж ажиллах болдог өдөрт. Өөрөөр хэлбэл тэр хүн цаасаар шүүгчийн гаргасан захирамжийг архивлаж янзалж эцэслэж гаргахын зэрэгцээгээр хамт тэр программыг хамт хөтөлж явах үүрэг хүлээдэг нэгхэн туслах.

Тэр нэг туслахын тэр 5, 6 программыг зэрэг хөтлөхийн тулд тэр хүний ажиллаж байгаа компьютер нь ямар компьютер байдаг вэ гэхээр хамгийн хоцрогдсон, хамгийн муухайгаар хэлбэл ашиглалтаас гарч ирсэн тэр л компьютерууд шүүхийн туслахуудын өмнө байж байдаг. Тэр 5 программ дээр зэрэг ажиллахын тулд нэгийг нь хийхэд л нөгөө 4 нь гагцхисан сууж байдаг. Ер нь бол бодит байдал бол ийм 1 дүгээрт. Яг ийм хүмүүс өнөөдөр бид нар та нар дүүргийн нэг иргэний шүүхийн веб сайт яаж ажиллаж байгааг хараарай. Тэр веб сайтын хөгжүүлэлт ямар байгааг хараарай. Түүнд ямар хүний нөөц анхаарал тавьж ажиллагдийг нь бас анзаараарай. Тэгээд бодохоор тэд нар бүгд хувийн мэйл хаягаараа хэргийн оролцогчийн хүсэлтийг хүлээж авдаг. Тэд нарт албан ёсны шүүхийн мэйл хаяг гэж байхгүй. Тэгвэл эргээгээд энэ бүхэн маань нөгөө иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны ер нь хэрэг

хянан шийдвэрлэх ажиллагааны Do process өөрөө хөндөгдөж байна уу үгүй юү гэдэг асуудал гарч ирнэ. Шүүхийн туслах хувийн мэйл хаягаараа хүмүүсийн хүсэлтийг хүлээж аваад, тэрийг нь хэвлэж орж ирээд шүүгчид өгөнгүүтээ дөнгөж саяхан өмгөөлөгч нь ийм нэг юу авчирлаа, хүсэлт өглөө хурал хойшлох нь л гэж хэлдэг.

Ер нь болбол сүүлийн үед яах вэ албан ёсоор баталгаажуулж байгаа хувийн мэйл хаягийг нь. Өөрөөр хэлбэл баталгаажуулж байгаа гэдэг маань гадаа шүүхийн гадаа ханан дээр наагаад тавьчихсан Баярмаа шүүгчийн туслах Золзаяагийн хаяг энэ шүү гээд тавьчихсан тэр хаягаар ирж байгаа хүсэлтийг болбол бид нар хүлээж авч байгаа. Тэнд хавсаргасан эрүүл мэндийн магадалгаа янз бүрийн баримтуудыг бид хүлээж авч байгаа, болох хэр хүчээрээ л ажиллаж байгаа. Гэхдээ энэ дээр болбол ямар ч байсан дэд бүтэц үнэхээрийн байхгүй тэнд 1 дүгээрт.

2 дугаарт юу ярьж байна нөгөө цахим нотлох баримтуудын асуудал. Жишээлбэл орон нутаг, нийслэлийн янз бүрийн эрх бүхий албан тушаалтнууд, дарга, дарга, цэргүүдийн тушаалууд нь цахим гарын үсэгтэй орж ирж байгаа л даа. Тэр цахим гарын үсэгтэй орж ирж байгаа баримтуудыг хэрхэн бэхжүүлэх, хэрэгт хэрхэн авч тусгах асуудал нь өөрөө бас жаахан ойлгомжгүй хэвээрээ байгаа. Шүүгч нар өөрийнхөө гар утсаар бар кодыг уншуулаад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг шинжлэн судлаад болчихжээ гэж үзэх юм уу эсвэл энэ хэн нэгэн хөндлөнгийн этгээд байх юм уу? Энэ процесс ажиллагаа болбол ойлгомжгүй байгаа. Энэ болгоныг болбол жижиг хэргийн энэ юун дээр болбол нарийвчлан тусгасан зүйл бол энд байхгүй. Гэхдээ энэ ганцхан жижиг хэрэг дээр тусаж орж ирээд бага үнийн.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Микрофон өгье 2-т гүйцээгээд хариулья.

Н.Баярмаа: Бага үнийн дүнтэй хэрэг дээр орж ирээд, тэгээд тэр нь тэр ердийн ажиллагааны журмаар шийдэгдэх бусад хэргүүд дээр үйлчлээд явна гэвэл бас худлаа болно. Тийм учраас бага үнийн дүнтэй хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процесс ажиллагааны хүрээнд энэ том асуудлыг бүхэлд нь шийдэх боломжгүй. Би яам бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг нэлээн яаруу хийж байгаа гэж ойлгож байгаа. Тэр хүрээнд бид нар болбол тодорхой хэмжээгээр цахим нотлох баримтын үнэлгээний асуудлыг бас шийдэж байгаа гэж харж байгаа. Товчхондоо яг одоогийн байдлаар санагдаж байгаа юм бол ийм хариулт өгөхөөр байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Тодруулах уу? Учрал гишүүний микрофоныг өгье.

Н.Учрал: Би яг өнөөдөр шүүх хурлыг цахимаар хий гэж хэлээгүй л дээ. Тэгээд яах вэ Энхбаяр сайд өөрөө сайд болоод долоо хонож байх шиг байна. Тэр Шүүхийнхээ ерөнхий зөвлөл дээр өөрөө очиж үзэхгүй юү. Тэрнээс биш дэд бүтцийг хүлээгээд хуулиа хийдэггүй улс ч гэж байхгүй л дээ. Хуулиа хийж байж дэд бүтцээ хийдэг. Хэрвээ энэ тохиолдолд Шүүх байгууллага хуулиа тэгвэл өөрөө татаж аваарай. Тэрийг өргөн мэдүүлэх шаардлагагүй шүү. Шүүх байгуулах хуулийг чинь би харсан. Тэр хууль дээр Нямбаатар сайд байхдаа тэр шүүхийн цахимжилт бол 1 дүгээр асуудал гэж өөрөө үзсэн.

2-т тэр IT-ийн төвийг чинь тэр хуулиараа байгуулж байгаа юм байна лээ. Бид бэлэн байна гээд байсан. Шинэ сайд бол бид бэлэн биш гэж байгаа юм байна. Тийм болбол наад Шүүх байгуулах хуулиа татаж аваарай. Шүүхийг цахимаар хий гэж би ерөөсөө огт хэлээгүй. Та нар ядаж шүүх хуралдааны товыг хойшлуулахыг цахимаар авчхаж байж авчхаач гэсэн. Дэд бүтэц байхгүй бол энэ яамандаа хэлээд төсөв мөнгөө яриад чухал асуудал дээр төсвөө шийдээд л явах ёстой шүү дээ.

Д.Цогтбаатар: Энхбаяр сайдад микрофон өгье.

Б.Энхбаяр: Үгүй ээ энд эсэргүүцээд байгаа юм байхгүй. Энэ процессын хуулийг бид даруй хэрэгжүүлэх гэж байгаа байхгүй юу. Энэ процессын хуулийг даруй хэрэгжүүлэхэд бол бэлэн биш байгаа. Иргэний хэргийн процессын хуулийг шинэчилсэн найруулга хэлбэрээр боловсруулж байгаа юм. Энэ процесс бол шүүхийн энэ цахимжилтын системчлэлтэй уялдаж явагдана. Улсын дээд шүүх Солонгосын хамтын ажиллагааны байгууллагатай хамтраад дунд хугацаанд нэлээн олон тэрбумын том төсөл хэрэгжүүлэх гэж байгаа юм. Модель нь гарчихсан байна. Тэгэхээр энэ процесс нь Шүүх байгуулах хуультайгаа уялдаж авах гээд байгаа байхгүй юу. Би түрүүн Шүүх байгуулах хуулийг би 26 оны 1 сарын 1-нээс үйлчлэхээр хуулийн төслийг өргөн барих гэж байгаа гэдгийг би зүгээр хэлээгүй байхгүй юу. Би энэ шүүхийн цахимжилтын процесстэй бас холбож хэлээд байгаа байхгүй юу. Энэ төслийн хэрэгжих хугацаатай нь бас холбож хэлээд байна гэсэн үг. Тийм. Тэрнээс.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон өгье.

Н.Баасанжав: ШЕЗ-ийн хувьд болбол бид 22 оны 12 сарын 7-нд бол шүүхийн системд шинэ арга технологийг нэвтрүүлэх буюу товчоор бол цахимжуулалтын бодлогоо ер нь баталсан өөрсдийн түвшинд. Шүүх эрх мэдлийн бодлогын баримт бичиг буюу Шүүхийн тухай хуульд заасан Улсын Их Хурлаар орох баримт бичигтэй мөн цахимжуулалтын асуудлыг тусгаад өргөн барьсан байгаа. Эрх зүйн орчны хувьд болбол цахимжуулалтыг дэмжих бодлогоо бол бид нар явуулаад байгаа юм. Тэр бодлогыг дагаад процессын хуулиудад бол цахимжуулалтын заалт орох ёстой. Түүнийг одоо эхэлж байгаа нэг нь болбол энэ хялбар ажиллагаа буюу шуурхай илүү ажиллагааг шуурхай явуулах энэ процесс

бол ИХШХШТ хуульд орж ирж байна гэж харж байгаа. Тэгэхээр ер нь ИХШ-аас бас явж байгаа нь өөрөө бас их зөв байгаад байгаа юм. Талуудын зарчим дээр үндэслэсэн, талууд сайн дураараа нотлох баримтаа бүрдүүлдэг энэ ажиллагаанаас эхэлчихвэл ер нь цахим хавтаст хэрэг.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофоныг өгье, гүйцээгээд хариулъя.

Н.Баасанжав: Тэгэхээр энэ цахим цахимжуулалт гэдэг ерөнхий нэр томъёог бас хэрэглэмээргүй байгаа юм цаашид. Цахимаар мэдүүлэх, цахим нотлох баримтыг шүүхэд хэрэглэх гэдэг энэ зүйл болбол энэ ИХШХШТ хуульд, ялангуяа энэ хялбар ажиллагаанаас эхлээд явах юм байна. Тэгээд үе шаттай явах юм байна гэж гэж бид хараад байгаа юм. Тэгэхээр одоо болбол Баярмаа шүүгч хэлж байна, сайд хэлж байна. Яг шүүхийн өнөөгийн нөхцөл байдал бол hardware буюу бол мэдээж хоцрогдсон байгаа, зүгээр software талдаа бид нар системийг хөгжүүлэх талдаа яаж байна гэхээр яг манай дээр энтерпрайз архитектур буюу ТЭЗҮ хийгдэж байгаа. Тэгэхээр энэ 11 сарын сүүлээр, жоохон сунгалаа гэхэд 12 сард бид нар шүүхэд хэрэглэх нийт систем маань ямар байх юм, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой нь ямар байх юм, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас бусад нь ямар байх гэдэг зургаа гаргачихна. Түүн дээр ер нь төсөв суучихна. Тэр төсвөө бид нар бодлого хэрэгжүүлэхдээ тооцчихсон 27 тэрбум орчим төгрөгийн төсөвтэй маань яаж уялдах нь вэ гэдгийг бас харж байна. Тэгэхээр тэр зураглал гарна.

Шүүх хуралдаан болбол ковидын үед бид нар бол харж байсан, тодорхой хэмжээгээр бид нар бас баримтуудыг аваад шүүх хуралдааныг зайнаас ингээд хийж байсан шүү дээ. Тэр маань бас түлхэц болсон бид нарт бас. Түүн дээр алдсан, оносон туршилагууд байна. Одоо бол бид нийт ер нь цахим баримт бичиг гэдэг чинь юуг ойлгож байгааг бол мэдэж байгаа. Нийтийн мэдээллийн ил тодын

тухай хууль дээр 4.1.9-д заасан цахим баримт бичиг гэж анхнаасаа үйлдэгдсэн хэлбэр нь өөрөө цахимаар байхаас эхлээд гэдгийг бид нар ойлгож байна. Тэр Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 38 дээр ч гэсэн тэр баримт нь өөрөө цахимаар эсхүл цаасаар үйлдсэн байвал яах юм гэдэг. Тэгэхээр энэ баримт анхнаасаа зөвхөн цахим хэлбэр дээр үйлдэгдээд явчихвал түүний хүчин төгөлдөр дээр бас маргаад байхгүй. Тэгээд ер нь бол дэд бүтэц бол гадна талдаа үүсчихсэн. Гагцхүү бид нар өөрсдийнхөө шүүхийнхээ яг hardware болон тэр компьютер тоног төхөөрөмжийнхөө асуудлыг шийдээд, одоо бид нарын гаргаж байгаа зураглалаар энэ систем гарчихвал ер нь болох гээд байна.

Гэхдээ тодорхой хугацаа хэрэгтэй байгаа. Хуульдаа одоо оруулчихвал энэ хуулиа дагаад бид нар бас энэ software-ээ хийх нөхцөл бол бүрдчих юм байна. Түүндээ тохируулаад хэргийн хөдөлгөөнөө бид нар бас хийчихнэ. Тэгэхээр ер нь бол бас энийг явуулах хэрэгтэй. Жоохон нэг цаг хугацаа, жоохон тийм санхүүгийн асуудал байгаа, тэрнээс биш бол боломжтой гэж харж байгаа. Бусад оронд ч гэсэн нэгэнт нэвтэрчихсэн байгаа юм чинь. Тэгээд бусад орны туршилагыг л өөрийн онцлогт тохируулаад нэвтрүүлчихэд бол маш их цаг хүч тэр одоо энэ хүн шүүхэд ирэхгүйгээр ядаж цахимаар мэдүүлэх нөхцөл бол бүрдэнэ л гэж хараад байгаа юм.

Д.Цогтбаатар: Учрал гишүүн.

Н.Учрал: Энэ шүүгчийн туслах 5 янзын программ хэрэглэж байгаа, тэр компьютерынх нь хүчин чадал муу гээд проблем байгааг болбол бүрэн ойлгож байгаа. Тийм. Тэрийг бол үнэхээр шийдэх ёстой. Өнөөдрийн байдлаар маргаан гараад бүгд цахимжсина гэж бол байхгүй шүү дээ. Тэгэхээр тэр бодлогын баримт бичгээ гаргаад, хууль дүрмээ гаргаад, төсөв мөнгөө шийдээд ингээд цаг алдахгүй урагшилъя гэдэг. Би тэр 26

оноос хэрэгжүүлэх гээд байгаа саналыг нь бас Энхбаяр сайдынхыг ойлголоо.

Тэгээд ерөөсөө л бүгдээрээ нэг иргэн талдаа хүнд суртал багатай л байлгая л гээд байгаа юм. Нэг ёсондоо цахимжуулалт гэдэг чинь өөрөө амьдрал дээр бүр илүү хүнд суртал үүсгэх тал руу яваад байна шүү дээ. Цахимаар бичиг авна, цаасаар хэвлэнэ, архивлана, давхар давхар ажил хийгээд байдаг. Тэгэхээр энэ олон асуудлуудыг чинь, энэ механик ажлуудыг нь цөөлж, энэ шүүгчийн туслах гэдэг хүний ачааллыг бууруулахад энэ сайн технологиуд хувь нэмрээ оруулах ёстой болохоос биш давхар хүнд суртал үүсгэж болохгүй. Тэгэхээр өнөөдөр хүнд байна гээд суугаад байна гэвэл энэ явахгүй. Тийм учраас энэ төсөв.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Асуулт асууж, хариулт авч дууслаа. Гишүүддээ хандаад хэлье. Яах вэ би бас шинэхэн дарга байгаа болохоор жоохон либерал хандаад байгаа. Либерал хандаж байгааг миний сул тал гэж үзэж болохгүй шүү. Цаашидаа дэгээ барина шүү, сул байна гэж андуурч болохгүй шүү. Ингээд юу хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байвал саналаа өгье. Үг хэлэх гишүүд нэрээ өгье. Тэгвэл үг хэлэх гишүүн байхгүй байна. Би тэгвэл товчхон ганц, хоёр санаа хэлчихье. Раднаасэд гишүүн, нэрээ өгөөгүй байна шүү дээ. Раднаасэд гишүүн үгээ хэлье.

Ш.Раднаасэд: Богино хугацаанд хэрэг шийдээд энэ агуулга талаасаа бол зөв л дөө. Жоохон шүүх дээр очихоор хүндэрдэг, удааширдаг, гацдаг. Гэхдээ болж өгвөл энийг хийхдээ нэг л зүйлийг анхаар. Энэ улсын туршилага, тэр улсын туршилага яах вэ байж болно, байж болно, тэр дэлхийтэй хөл нийлэлгүй л яах вэ. Энэнээс болоод хэн нэгэн яг ингээд хохирчих вий гэж муу талаас нь л их бодоорой доо. Хамаг бодол муу юмаа дуусгаж байж л энэ үг үсгийг нь тавихгүй болбол энэний процесс ялангуяа энэ том хуулиуд дээр нэг жижиг хөдөлгөөн хийхэд л маш их хэмжээний юм цаана нь хөдөлдөг гэдгийг ерөөсөө мартаж

болохгүй. Одоо энэ бага үнийн дүнтэй гээд л ингэж байна, 11 сая төгрөг. Энэ 11 сая төгрөг зарим хүнд их үнийн дүн байгаа шүү. Бодоход энэний цаана ямар ямар хэргүүд байх вэ гэхээр нь өнөөдөр явж байгаа шүүхийн хэргүүдээс гадна зөндөө олон юм цаана чинь дахиад л байгаа шүү. Үүсэж болзошгүй шүү. Энийг ашиглаад тэгээд иргэд дээр шүүхийн шийдвэрээр дарамт үүсгэдэг, эргээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар дээрээ бас дарамт болдог нэг ийм юм давхар үүсэх вий.

Би бодохдоо энэний цаана мэдээж зээлийн юм орохгүй гэж байна, барьцаа баталгааны юм энэ лизинг чинь орох уу яах вэ одоо бас сайн мэдэхгүй юм. Хэрвээ тийм болбол тэгээд бас нэг шүүхийн шийдвэр бариад л ингээд л дарамт чирэгдэл үүсээд л, 45 хоногийн дотор асуудал нь дуусчихсан. Шүүхийн шийдвэр гарчихсан гээд л ингээд, ингээд л ард иргэд дээр бөөн чирэгдэл учруулаад явчих вий. Тэрний чинь цаана хүмүүсийн амьдрал байгаа гэдгийг аягүй сайн бодож хийх ёстой. Ажлын хэсэг гарах юм бол тэгээд бүх талаас нь сайн оролцуулж, ялангуяа энэ хуучин тэтгэвэрт гарсан шүүгч нараа жоохон оролцуулж юм хиймээр байна. Байнгын хорооны даргаа. Тэтгэвэрт гарчихсан шүүгч нарыг, прокуроруудыг. Эд нар дээр чинь их, тэд нар яах вэ өөрсдийнхөө түвшинд ойлгож юм ярьж байгаа ч гэсэн тэд нарын чинь туулсан туршилага зовлон нь өөрөө бодит амьдрал байгаа байхгүй юу. Тэгээд энэ улсыг мэддэг, тэр улсыг мэддэг гээд гадна, дотно төгссөн гээд нэг жаал хүн авчраад хийчихдэг. Тэрийг бол сэтгэл хөдлөлөөр энэ процесс, ялангуяа энэ хүний эрхтэй холбоотой юмнууд дээр маш сайн тооцож хийх ёстой юм болов уу л гэж бодож байна. 35 секунд хэтрүүлчихлээ уучлаарай.

Д.Цогтбаатар: Ингээд хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж гишүүд үг хэлж дууслаа. Би үг хэлье гэж байсан, тэгвэл энийгээ татлаа. Санал давхцаж байна. Ингээд санал хураалт явуулъя. Иргэний хэрэг шүүхэд хянан

шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая 60 хувийн саналаар дэмжигдлээ. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлаар хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хууль, хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Адъяаа уншиж танилцуулна.

20.08 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

